

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 99047408 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:99013699 Цахим хаяг:tsetsegsuren.a@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нарантуул
Утас: 70432545 Цахим хаяг: narantuuld@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Мөнхтулга
Утас:7043-2545 Цахим хаяг: : munkhtulga.d@audit.gov.mn
Аудитор: Ц.Гантулга
Утас:7043-2545 Цахим хаяг: Gantulgats@audit.gov.mn
Аудитор: Д.Балжинням
Утас:7043-2545 Цахим хаяг: Baljinnyamd@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товч	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6
БҮЛЭГ 1. Салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа зарим бодлогын баримт бичгийг сайжруулан хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн шинэ жилийн эхлэх хугацаа, сургуульд элсэх насыг өөрчилснөөр сургалтын чанар, хүртээмжид ахиц гаргах боломж байна.	6
A.1 Хуульд өөрчлөлт оруулах замаар ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн шинэ жил нь 9 дүгээр сарын эхний 7 хоногийн даваа гаригт эхлэхээр зохицуулах шаардлага байна.	6
A.1.1 Салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа зарим бодлогын баримт бичгийг сайжруулснаар сургалтын чанар, хүртээмжид ахиц гаргах боломж байна.	8
A.1.2 Орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг сургалтын үйл ажиллагаанд чиглүүлэх шаардлагатай байна.	8
A.2 Боловсролын салбарт 2016-2018 онд 3 тэрбум 500.0 сая төгрөгийн төсөвтэй томоохон бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн зарим сургуулийн нэг ангид стандартаас илүү суралцагч суралцаж байна	10
A.2.1 Аймгийн ИТХ-аас хуулиар зохицуулсан чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.	10
A.2.2 Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа барилга байгууламж, сургалтын үйл ажиллагааг хангахуйц түвшинд засварлах шаардлагатай байна.	12
A.2.3 Зарим мэргэжлийн боловсон хүчин ажлын байрны тодорхойлолтод заасан шалгуур нөхцлийг хангаагүй, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан багшийн судалгаагүй байна.	19
A.3 Төсвийн төлөвлөлт бодитой бус, тусгай зориулалтын шилжүүлэг, зардлын зарцуулалтад тавих хяналт сул, төсөв хэмнэх боломжийг алдаж байна	22
A.3.1 Хувьсах зардлыг тооцох тогтоолыг шинэчлээгүй, хэрхэн хуваарилах талаар аргачлал байхгүйгээс төлөвлөлт алдаатай төлөвлөгдөж, сургуулиудын нормативт зардлын хэмнэлтийг бусад хүрэлцэхгүй зардалд гүйлгэн зарцуулж байна.	22
A.3.2 С Зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянахгүйгээр сарын батлагдсан хуваарийн дагуу олгож байна.	25
B.1 Бүх нийтийн ерөнхий боловсролыг хөтөлбөр төлөвлөгөөний дагуу эзэмшүүлэн, сургалтын чанарт үнэлгээ хийн дүгнэлт зөвлөмж өгч байгаа ч сургалтын чанарт дорвитой ахиц гараагүй байна.	28
B.1.1 Бүх нийтийн боловсролын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу эзэмшүүлж байна.	28
B.1.2 Эзэмшвэл зохих боловсрол, ур чадварыг олгож байгаа боловч сургалтын чанар харилцан адилгүй байгааг сайжруулах шаардлагатай байна.	30
B.2 Боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналтыг хэрэгжүүлжүүлэн, үр дүнг тооцож байгаа ч ахиц гараагүй байна	32
B.2.1 Үе шатны хяналтыг хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллаж байгаа боловч чанарт ахиц гараагүй байна.	32
B.2.2 Аймгийн мэргэжлийн хяналтын газраас хийгдсэн төлөвлөгөөт шалгалтаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох боломжгүй байна.	33
ДҮГНЭЛТ:	35
ЗӨВЛӨМЖ:	35
ХАВСРАЛТУУД:	33
Холбогдох байгууллагын санал:	
Саналд өгсөн тайлбар:	

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын их хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗД	Засаг дарга
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
БМДИ	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
БСУГ	Боловсрол, соёл. Урлагийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТББ	Төрийн бус байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЦАЦС	Цаст-Алтай цогцолбор сургууль
БҮТ	Боловсролын үнэлгээний төв
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СДҮА	Сургалтын дэмжих үйл ажиллагаа

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хэрэгжсэн дэд хөтөлбөрүүд	10
Хүснэгт 2	Нийт ажилчдын судалгаа	19
Хүснэгт 3	Суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг тогтоосон шалгалтын судалгаа	30
Хүснэгт 4	Сургуулиудад хийсэн шалгалт, үнэлгээний дүн	33

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Сайн туршлага	18

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Анги дүүргэлт	11
Дүрслэл 2	Сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилга байгууламж	12
Дүрслэл 3	хамрагдсан дүн мэдээ Кабинет ашиглалт	14
Дүрслэл 4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаа	17
Дүрслэл 5	Хүүхдийн 108 утасны дуудлага	18
Дүрслэл 6	Багш нарын мэргэжлийн зэрэг, боловсролын түвшний судалгаа	20
Дүрслэл 7	2017-2019 оны батлагдсан төсөв	22
Дүрслэл 8	Дотуур байранд амьдарч байгаа 6 настай хүүхдийн тоо	24
Дүрслэл 9	Санхүүгийн тайлангийн аудитын алдаа зөрчил, дүгнэлтийн байдал	25
Дүрслэл 10	Бага, дунд боловсролын хамран сургалт/сүүлийн 3 жилээр	28
Дүрслэл 11	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	29
Дүрслэл 12	ЕБС-ийн багш нарын шалгалтад хамрагдсан дүн мэдээ	31

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1		
Хавсралт 2		

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудит хийх үндэслэл, бүрэн эрх Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/100 дугаар тушаалын дагуу “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийнэ. Аудитын зорилт “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”д улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: ➤ Ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх; ➤ Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт хангагдаж байгаа эсэх; Аудитын хамарсан хүрээ Аудитыг аймгийн БСУГ-аар, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн 25 сургууль, 2 насан туршийн боловсролын төв, 1 лицей сургуулиудын 2016-2019 оны үйл ажиллагааг /сүүлийн 3 хичээлийн жил/ хамруулан гүйцэтгэлээ. Аудитын хугацаанд Жаргалант сумын 7 сургууль, хөдөөгийн 9 суманд томилолтоор ажиллаж холбогдох горим сорилыг хэрэгжүүлсэн болно. Аудитын хязгаарлалт Аудитын хугацаанд өнгөрсөн 2016-2019 оны 3 оны хичээлийн жилийн баримт материалд түшиглэн тоон мэдээлэл дүгнэлт хийх,архивын баримт материалтай танилцахад аймгийн БСУГ-ын болон сумдын сургуулийн нэгдсэн архивын мэдээ, тайлан, судалгаа нь иж бүрэн архивлагдаагүй байгаа нь хүндрэлтэй байлаа. Мөн Аймгийн МХГ-ын барилгын болон байгаль орчны чиглэлийн байцаагч нь тэтгэвэрт гарсан, эрүүл ахуйн чиглэлийн байцаагч нь тайлан мэдээ өгөхөөс татгалзсан тул шаардлагатай мэдээллээ бүрэн авч чадаагүй болно Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, сүүлийн 3 жилийн байдлаарх үндсэн үзүүлэлтийн судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав. Аудитын бүрэлдэхүүн, хугацаа Аудитыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар удирдаж, аудитын менежер А.Цэцэгсүрэн чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нарантуул, Д.Мөнхтулга, аудитор Д.Балжинням, Ц.Гантулга нар гүйцэтгэв. Аудитын төлөвлөгөөг 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн дотор батлуулж, талбарын ажлыг 2020 оны 09 дугаар сарын 02-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 28-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайлан, судалгааг 2020 оны 10 дүгээр сарын 28-ний өдрийн дотор хүлээн авч нэгтгэх бөгөөд аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан тэргүүлэх аудиторов тушаалаар баталгаажуулж, УАГ, Аймгийн ЗД, ИТХ, аймгийн БСУГ, бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.
--	--

БҮЛЭГ 1. Салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа зарим бодлогын баримт бичгийг сайжруулан хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн шинэ жилийн эхлэх хугацаа, сургуульд элсэх насыг өөрчилснөөр сургалтын чанар, хүртээмжид ахиц гаргах боломж байна.

Хуульд өөрчлөлт оруулах замаар ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн шинэ жил нь 9 дүгээр сарын эхний 7 хоногийн даваа гаригт эхлэхээр зохицуулах шаардлага байна.

А.1.1.1 Бага дунд боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1¹-д заасны дагуу 2016-2019 оны хичээлийн жил 9 дүгээр сарын 1-ний өдөр эхэлж хэвшсэн, гэвч БСШУС-ын сайдын 2020 оны А/244 дүгээр тушаалаар 2020-2021 оны хичээлийн жил ба улирлын амралтыг даваа гаригт эхэлж, баасан гаригт дуусахаар тусган мөрдүүлж байгаагаас үзэхэд хуулийн заалттай сайдын тушаал уялдахгүй байна.

А.1.1.2 Аймгийн БСУГ-аас сурагчдын оролцоо ирцийн байдалд хийсэн хяналт үнэлгээний дүнгээр сурагчдын улирлын хичээл эхлэх өдрүүдэд ердийн өдрүүдээс сурагчдын ирц аймгийн хэмжээнд 67.4-88.5 хувьтай, хөдөөгийн сургуульд 48.8-77.8 хувьтай байна.

А.1.1.3 Хуульд заасан хичээлийн жил, улирлын амралт эхлэх өдөр 7 хоногийн эхний өдөр таараагүйгээс хөдөөгийн сурагчдын ирц хангалтгүй, 1 хүүхэд жилд 15-20 өдрийн хичээл тасалснаас сурлагын чанарт сөргөөр нөлөөлж байна. Иймд хуульд өөрчлөлт оруулах замаар ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн шинэ жилийг 9 дүгээр сарын эхний 7 хоногийн даваа гаригт эхлэхээр зохицуулах шаардлага байна.

А.1.1.4 Боловсролын салбарын хөдөлмөрийн онцлогоос хамааран багш, ажилчид орчны дуу шуугиан, агааржуулалт, өдөр тутам хичээлд хэрэглэж байгаа шохой нь стандарт бус зэргээс шалтгаалан эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж байгаагаас тэтгэвэрт гарах насандаа хүрэхгүй хорвоогийн мөнх бусыг үзэж байгаа тохиолдол сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна.

Салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа зарим бодлогын баримт бичгийг сайжруулснаар сургалтын чанар, хүртээмжид ахиц гаргах боломж байна.

А.1.1.5 Сургуулийн захирлыг Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.15² дахь заалтын дагуу сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн аймаг нийслэлийн Засаг дарга томилж чөлөөлж байсан бол хуульд өөрчлөлт оруулж 30.1.12³-д заасны дагуу сумын засаг дарга сургуулийн захирлыг томилж чөлөөлж байна. Орон нутгийн ээлжит сонгууль бүрийн дараа захирлуудыг сольж, ЕБС-дын тогтвортой хөгжлийг алдагдуулан эцэг эх, олон нийтийн тэгш оролцоог хангаж чадахгүй байна.

¹ “Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жил нь 9 дүгээр сарын 1-ний өдөр эхэлнэ.”

² 30.1.15-аймаг, нийслэлийн боловсролын газрын сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох, тэдгээрийг үр дүнгийн гэрээний хэрэгжилт болон аймаг, нийслэлийн боловсролын газрын саналыг үндэслэн чөлөөлөх;

³ 31.1.12-аймаг, нийслэлийн боловсролын газрын сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох, тэдгээрийг үр дүнгийн гэрээний хэрэгжилт болон аймаг, нийслэлийн боловсролын газрын саналыг үндэслэн чөлөөлөх;

Боловсролын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1⁴-д заасан заалт хэрэгжихгүй, эцэг эхийн зөвлөлийн саналыг харгалзахгүйгээр захирлыг томилох, чөлөөлөх шийдвэр гарч байна. Тухайлбал: 2016-2019 оны хичээлийн жилд аймгийн хэмжээний 24 сургуулиас Жаргалант сумын 7, Буянт сумын сургуулийн захирлаас бусад 22 захирлыг өөрчилснөөс, Жаргалант сумын 12 жилийн I сургууль, Булган сумын Минжит Булган цогцолбор сургууль, Дөргөн сумын ЕБС-ын захирлууд шүүхээр шийдвэрлэгдэж ажилдаа эргэн томилогдсон байна.

А.1.1.6 Бага дунд боловсролын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1⁵-д заасан сургуулийн зөвлөлийн оролцоот саналыг үндэслэн томилсон томилгооны шийдвэргүй байна. Иймд сургуулийн захирлыг томилох, чөлөөлөхдөө Боловсролын тухай хуулийн 35 дугаар зүйлийн дагуу сургуулийн зөвлөлийн чиг үүрэгт нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

А.1.1.7 Боловсролын тухай хуулийн 30.1.3⁶, 35 дугаар зүйлийн 35.3⁷-д сургуулийн зөвлөлд орох бусад байгууллагын төлөөллийг үүсгэн байгуулагчийн саналыг үндэслэн нийт ажилчдын хурлаас сонгохоор заасан нь хуулийн хэрэгжилтийг хангах нөхцөлтэй нийцэхгүй байна. Тухайлбал: Баруун хязгаарын Булган сумын ЕБС-ийн төрөөс орох төлөөллийг аймгийн Засаг дарга санал болгож байгаа нь сум орон нутгийн эрх мэдэл, оролцоог сулруулж, төвлөрлийг буй болгож байна. Иймд бусад байгууллагын төлөөллийг сумын засаг даргын бүрэн эрхэд хамруулахаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

А.1.1.8 Цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн үдийн хоол, үдийн цай хөтөлбөрийн хүрээнд хувьсах зардлын хэмжээ, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх, ЕБС-ын суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журмууд шинэчлэгдэн мөрдөгдөж байна.

Боловсрол соёл шинжлэх ухааны сайдын 2008 оны 113 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Анги алгасан суралцах хүсэлтийг шийдвэрлэх журам”-ын 2.1.1-д “...хот, аймаг, улс, олон улсын чанартай олимпиад, уралдаан, тэмцээнд оролцож 1-3 дугаар байр эзэлсэн байх” гэж заасан. Журмын болзлыг хангаад анги алгасан суралцах хүсэлт бага, дунд ангийн суралцагчдаас олноор ирдэг ч 1-5 дугаар ангид ямар ч хичээлээр улсын чанартай олимпиад явагддаггүй, энэ нь хүүхдүүдийн боловсролын үнэлэмжийг үнэлэхдээ тэгш бус байдлыг үүсгэж байна.

Засгийн газрын 2018 оны 382 тоот тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

А.1.1.9 Засгийн газрын 2018 оны 382 тоот тогтоолд хөдөө орон нутагт ажилласны нэмэгдлийг боловсролын салбарын тогооч, нярав, нягтлан бодогч, үйлчлэгч, эмч, сахиул, жижүүрүүдийг оруулаагүйгээс ялгавартай байдал үүсэж, адил орчин, нөхцөлд ажиллаж байгаа сургуулийн номын санч нэмэгдэл цалин авч байхад сургуулийн эмчид олгогдохгүй байгаа нь шүүмжлэл дагуулж байна.

⁴ “Боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлагыг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт сургуулийн болон цэцэрлэгийн зөвлөл... тус тус хэрэгжүүлнэ

⁵ 19.1. Ерөнхий боловсролын сургуулийн өөрийн удирдлага нь сургуулийн зөвлөл байна. Сургуулийн зөвлөл Боловсролын тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдан үйл ажиллагаагаа явуулна.

⁶ “орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах, асуудлыг аймаг нийслэлийн боловсролын газрын дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэх”,

⁷ “Сургууль цэцэрлэгийн зөвлөлд орох бусад байгууллагын төлөөллийг үүсгэн байгуулагчийн саналыг үндэслэн сургууль, цэцэрлэгийн нийт ажилтны хурлаас сонгоно.

Сургалтын хөтөлбөрийг өөрчилж, сургуульд элсэх насыг нэмэгдүүлснээр малчид тогтвор суурьшилтай хөдөлмөрлөх хөдөөгийн онцлогт тохирч байна.

А.1.1.10 БСШУСЯ-наас олон улсын байгууллагын дэмжлэгээр хэрэгжүүлсэн “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж 10 жил тогтвортой мөрдүүлж, үнэлгээ хийж сайжруулах зарчмыг баталсан нь сургалтын төлөвлөгөө тогтвортой байх боломжийг бүрдүүлж өгсөн хэдий ч Боловсролын тухай хуулийн 3.1.18⁸, 10.1⁹, 10.2¹⁰-д заалтыг хангах үүднээс “Сургалтын цөм хөтөлбөр”-ийг монгол хүүхдийн ахуйн онцлогт тохирч байгаа эсэхэд судалгаа, шинжилгээ хийх шаардлага байна.

А.1.1.11 Хүүхэд өөрөө олон хэлбэрээр сонирхож сэтгэдэг нь “Цөм” хөтөлбөрийн нэг чиглэлийн агуулгатай холбогдох тал дээр учир дутагдалтай байна. Тухайлбал: 6 настай хүүхдийг ЕБС-д элсүүлж байгаа өнөөгийн тогтолцоо нь хөдөөгийн ард иргэдийн ахуй амьдралтай төдийлөн нийцэхгүй байна. Хөдөөгийн багуудын айл өрхийн 70-аас илүү хувь нь хичээлийн шинэ жил эхлэхэд эхнэрүүд сум, аймгийн төвд хүүхдээ даган амьдарч, нөхрүүд аргагүйн эрхэнд ганцаараа малаа маллаж байна.

Төрөөс 6 настай хүүхдийн дотуур байрны сурч боловсрох аятай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, тэдгээрт зориулсан багш ажиллуулах зэрэг арга хэмжээ авсан ч сумдын дотуур байранд дунджаар 4-6 хүүхэд байрлан суралцаж байгаагаас ажлын ачаалал багатай байхад багшийг цалинжуулах нь төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

Сургууль бүр хөгжлийн зорилттойгоо уялдуулан дотоод хяналтыг хэрэгжүүлж, БСУГ-аас хөндлөнгийн хяналт хийгдсэн нь оновчтой арга хэмжээ болжээ.

А.1.1.12 Сургалтын хөтөлбөр төлөвлөлттэй уялдуулан “Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх журам”, “ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”, сургалтын хөтөлбөрүүдийн сайжруулалт, багшид мэргэжлийн зэрэг олгох, хасах журам, ЕБС-д кабинет, лаборатори байгуулах ашиглах нийтлэг журам, ЕБС-ийн сурагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах журам, “Цэцэрлэгийн сургуулийн орчинд гар утас, цахим болон сүлжээг зохистой хэрэглэх журам” зэрэг журмуудыг батлан мөрдүүлснээр сургууль, цэцэрлэгийн өөрийн удирдлагын эрх хэмжээг нэмэгдүүлж, төвлөрлийг сааруулах, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой болжээ.

А.1.1.13 БСШУСЯ-ны сайдын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/803 тоот тушаалаар сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх журмыг өөрчилсөн байна.

Шинэ журмаар тухайн сургуулийн хяналтыг өөрсдийнх нь мэдэлд шилжүүлж БСУГ-аас хөндлөнгийн хяналт хийгддэг болсон нь сургуулийн дотоод хяналт сайжрах, хөгжлийн зорилт төлөвлөлтүүдийг өөрсдийнхөө онцлогт тохируулан дэвшүүлж ажиллах боломжийг бүрдүүлсэн арга хэмжээ болжээ.

А.1.1.14 Түрээсээр авч байгаа номыг хичээлийн жил эхлэхэд олгохгүй бүтэн 1 улирал дуусаж байхад олгож байгаа нь хүүхдийн сурлагын чанарт сөрөг нөлөө үзүүлж байна. Энэ

⁸ “сургалтын цөм хөтөлбөр” гэж тухайн шатанд суралцагчийн эзэмших мэдлэг, үр чадвар, төлөвшилийн түвшин, түүнд хүрэх цогц үйл ажиллагааны ерөнхий зохион байгуулалтыг илэрхийлсэн баримт бичиг.”

⁹ “Боловсролын агуулга нь суралцагчийн нас, бие, сэтгэхүйн онцлог, авьяас, сонирхол... хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.”

¹⁰ “Тухайн шатны боловсролын агуулгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хөтөлбөрөөр зохион байгуулна.

нь шинэчлэгдсэн стандартаар хичээлийн жил эхлэхэд сургалтын ном хэвлэгдэж амжихгүй байгаатай холбоотой байна.

А.1.2 Орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг сургалтын үйл ажиллагаанд чиглүүлэх шаардлагатай байна.

А.1.1.15 Дэлхийн банк, Швейцарын Хөгжлийн агентлагийн дэмжлэгээр хэрэгжиж буй төслийн хүрээнд Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг ТББ-ын тусламжтайгаар 2016 оноос “Олон нийтийн оролцоот сургууль” төслийг 10 сургуульд хэрэгжүүлж сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, олон нийтийн бүтээлч оролцоог сайжруулах загварыг бий болгох зорилт дэвшүүлсэн байна.

А.1.1.16 Ерөнхий боловсролын сургуулиуд нь өөрсдийн санаачилгаар олон улсын байгууллага буюу хандивлагч байгууллагуудаас санал болгосон төсөл хөтөлбөрүүдээс өөрийн сургуулийн онцлог, үйл ажиллагаанд тохирсон үр өгөөжөө өгөх хөтөлбөр арга хэмжээ сонгож хэрэгжүүлэхгүй байна. Өөрөөр хэлбэл төсөл авч мөнгө зарцуулна гэсэн хандлага давамгайлж байна.

Ховд аймгийн хэмжээнд 2016-2020 онуудад дараах дэд хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

/Хүснэгт-1 Хэрэгжсэн дэд хөтөлбөрүүд/

д/д	Хөтөлбөрүүд	Санхүүжих эх үүсвэр				Гүйцэтгэл	Хувь
		Улсын төсвөөр	ОНХС	ААН, байгууллага	Бүгд		
1	"Оюун түлхүүр"		130		130	8.5	6.5
2	"Номын гэгээ"	0.9	81.5		81.5	81.5	100
3	"Авьяас"	5	121.6	39.4	166	166	100
4	"Хүүхэд бүр цэцэрлэгт"		90		90	90	100
5	"Чадварлаг багш"	50.8	30		80.8	80.8	100
6	"Олон үндэстэн ястны өв соёл"		10		10	10	100
7	"Цахим номын сан"		68.3		68.3	68.3	100
8	"Олон нийтийн оролцоот сургууль-хүний хөгжлийн төв"		90		90	81.4	90.4
Дүн		56.7	621.4	39.4	716.6	586.5	81.4

Хөтөлбөрөөр хэрэгжих хөрөнгийг ширээ сандал, компьютер, принтер гэх мэт материаллаг байдал руу чиглүүлж байгаа нь сургалтын үйл ажиллагааг онилохгүй байна. Тухайлбал: Чадварлаг багш хөтөлбөрт аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 2019 онд тусгасан төсөв улс аймгийн олимпиадад оролцуулсан сурагчдаараа амжилт гаргасан багшийг урамшуулах болохоор өөр зүйлд зарцуулагдсан байна.

Цаашдаа олон дэд хөтөлбөрөөс татгалзаж утга агуулгын хувьд нэгтгэн үр дүнтэй цөөн тооны хөтөлбөр хэрэгжүүлэх нь оновчтой байна.

А.2 Боловсролын салбарт шинээр 2016-2018 онд 3 тэрбум 500.0 сая төгрөгийн төсөвтэй томоохон бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн ч зарим сургуулийн нэг ангид стандартаас илүү суралцагч суралцаж байна.

Аймгийн ИТХ-аас хуулиар зохицуулсан чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

А.2.1.1 Аймгийн ИТХ, Боловсрол, соёлын талаар хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрүүдийн талаар холбогдох албан тушаалтнуудын мэдээллийг 2020 оны тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн тогтоолоороо аймгийн Засаг дарга, Боловсрол соёл, урлагийн газрын дарга, насан туршийн боловсролын захирал нарт үүрэг чиглэл өгсөн байна.

Орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулаагүй байгаа нь Боловсролын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2¹¹-т заасан чиг үүргийг аймгийн ИТХ-аас хэрэгжүүлээгүй байна. БСУГ аймгийн ИТХ-д 2019, 2020 онуудад боловсролын салбарын хүрээнд хэрэгжиж байгаа үндэсний болон орон нутгийн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тайлагнан ажилласан байна.

А.2.1.2 Хуулийн заалтыг хэрэгжүүлэхгүйгээс тогтоолоор үүрэг чиглэл өгч байгаа нь УИХ-ын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024/, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт зэргийг хэрэгжүүлэх Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн холбогдох заалтад нийцэхгүй байна.

Зарим сургуулийн нэг ангид стандартаас илүү суралцагч байгаа нь багш хүүхэд бүрд хүрч ажиллах боломжийг бууруулж байна.

А.2.1.3 Статистик үзүүлэлтээр бүлэг дүүргэлт дунджаар стандарт түвшинд байгаа хэдий ч нэг ангид байх хүүхдийн тоо стандартаас илүү буюу цөөн тоогоор бүрдүүлсэн сургуулиуд байна. Тухайлбал: Цаст-алтай цогцолбор, Прогресс сургууль, 12 жилийн 1 дүгээр дунд сургуулиудын бага ангид стандартаас 15-20 хүртэл хүүхдээр илүү, Дуут, Эрдэнэбүрэн, Мянгад сумдын ахлах ангид харьцангуй цөөн сурагчид хичээллэж байна.



/Дүрслэл-1 анги дүүргэлт/

Энэ байдал нь тойргийн хамран сургах хүүхдийн тооны хязгаарыг баримтлахгүй байгаатай холбоотой байна. Тойргийн хамран сургалтын хүүхдийн тоо хэтэрч хичээллэдэг нь тухайн сургуулийн багш нарын чадвар, сургалтын болон хүүхдэд ээлтэй орчин, материаллаг бааз, амран сургах тойргийн хүүхдийн байршил, хаягаа тухайн сургуулийн байршилд тохируулан өөрчилж тодорхойлуулдаг зэрэг шалтгаантай холбоотой байна.

ЕБС-ийн орон нутгийн хэрэгцээ шаардлага, хамран сургалтын судалгаанаас харахад 2017-2019 онуудад сургуульд хамрагдвал зохих 6-17 насны 61892 хүүхдээс тухайн онуудад 56464 хүүхэд суралцаж байгаа нь нийт хүүхдүүдийн 91.2 хувь хамрагджээ.

2017-2019 оны хичээлийн жилүүдэд сургуулийн нормативд хүчин чадлаар 45401 суралцагч суралцахаас 56464 хүүхэд суралцаж, хүчин чадлаас илүү 11063 суралцагч суралцсан байна.

2016-2018 онд 200 хүүхдийн хүчин чадалтай 3 тэрбум 500.0 сая төгрөгийн төсөвтэй бүтээн байгуулалт хийгджээ.

А.2.1.4 Аймгийн хэмжээгээр 2016-2018 онуудад шинээр Мөст сумын сургуулийн дотуур байр, Жаргалант сумын 7 дугаар сургуулийн дотуур байр, биеийн тамирын талбай, урлаг, спортын заалны барилгууд шинээр ашиглалтад орсон.

¹¹ “орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих


Жаргалант сумын 7 дугаар сургуулийн дотуур байр, биеийн тамирын талбай, урлаг, спортын заалны барилга ашиглалтад орсноор 100 хүүхэд багш, ажилчид эрүүл аж төрөх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх цэвэрхэн таатай сайхан орчин бүрдсэний дээр ажлын байр 14-өөр нэмэгдсэн үр өгөөжтэй бүтээн байгуулалт болжээ.

Зарим барилга байгууламж стандарт шаардлагыг бүрэн хангаагүй, орчны ерөнхий шаардлагын зарим заалтуудыг хэрэгжүүлээгүй, шаардлага хангасан хяналтын камер суурилуулаагүй, салбарын хөрөнгө оруулалтын нэгдсэн судалгаагүй байна.

Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа барилга байгууламж, сургалтын үйл ажиллагааг хангахуйц түвшинд засварлах шаардлагатай байна.

А.2.2.1 Аймгийн хэмжээнд төрийн өмчит 25 ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрны барилга байгууламжийн насжилтын судалгаа хийхэд 34.9 хувь нь 0-15 жил, 14.0 хувь нь 16-30 жил, 30.2 хувь нь 31-45 жил, 14.0 хувь нь 46-60 жил, 7.0 хувь нь 60-95 жил насжилттай байна. Харин дотуур байрны барилга байгууламжийн 23.5 хувь нь 0-15 жил, 9.5 хувь нь 16-30 жил, 52.4 хувь нь 31-45 жил, 14.3 хувь нь 46-60 жилийн насжилттай барилгууд тус тус эзэлж байна. Үүнээс 1929 онд ашиглалтад орсон 91 жил сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа Цаст алтай цогцолбор сургуулийн барилга байна.

/Дүрслэл-2 Сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилга байгууламж/



А.2.2.2 Аймгийн 43 хичээлийн байрнаас 16.2 хувь буюу дор дурдсан 7 байрны барилга стандарт шаардлагыг бүрэн хангахгүй байна. Үүнд:

- Манхан сумын сургуульд 1979 онд анх ашиглалтад орсон 440 суудалтай хичээлийн барилгын коридорын шал цөмөрсөн, хөдөлгөөнд орсон,
- Ховд сумын спортын заалны шал цөмөрсөн, хөгцөрч мөөгөнцөр үүссэн,
- Чандмань сумын сургуулийн спорт заалны дээвэрт байршуулсан харилцаа холбооны антен унаж барилгын даацын хананд цууралт үүсгэсэн боловч холбогдох байгууллагад уламжилсан ч өнөөг хүртэл арга хэмжээ аваагүй,
- Жаргалант сумын 7 дугаар сургуулийн хичээлийн барилга нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2011 оны 9 дүгээр сард ашиглалтад орсноос хойш өвлийн улиралд хана, цонх, дээвэр, цонхны амлагаа, булангийн уулзвараар дулааны алдагдал ихтэй талаар удаа дараа холбогдох газруудад уламжилж 2018 онд их засвар хийгдсэн боловч дулааны алдагдал буураагүй, улсын байцаагчийн 2019 оны дүгнэлтээр “сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламж”, Барилгын норм дүрэм БНБДИ-66-88-ын 8.2 дахь заалтыг зөрчиж байгаа тухай дүгнэлт гарсан ч ажиллаж байгаа,
- Дуут сумын сургуулийн барилга 1975 онд ашиглалтад орсон аймгийн МХГ-ын улсын байцаагчийн 2019 оны 8 дугаар сард хяналт шалгалтаар барилгын гадна талын шавардлага, өнгө будаг муудсан, суларсан, доторх шавардлага, будаг

шохой замаск халцарч хуурсан, цахилгааны монтаж стандарт, ашиглалтын шаардлага хангахгүй, галын аюулгүйн дүрэм зөрчсөн, дээврийн хар цаас хуурсан, дээвэр ханаар дулаан их хэмжээгээр алддаг, дотор халаалтын трубанууд олон хэсэг газар цоорсон, хар камераар ороосон, шугам сүлжээ, тоног төхөөрөмж ашиглалтын шаардлага хангахгүй зэрэг зөрчлүүд илэрч, дээрх зөрчлүүдийг арилгах ажиллах шаардлага хүргүүлсэн боловч санхүүгийн эх үүсвэргүйгээс шийдвэрлэгдээгүй,

- Манхан сумын сургуулийн 192.9 сая төгрөгийн өртөгтэй байгууламжийг анх дотуур байрны зориулалттай баригдаж байгаад барилгын үйл ажиллагаа зогсож 1999 онд ашиглалтад орж сумын эмнэлэг ашиглаж байгаад шинээр эмнэлгийн барилга баригдсан учир буцаан сургуульд өгсөн байна. Гэтэл сумын эцэг эхчүүд эмнэлгийн байранд үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөггүй, сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулах зориулалтын бус ашиглах боломжгүй,
- 2019 онд УТХО-аар Мөст сумын сургуулийн 1 дүгээр хичээлийн байранд их засвар хийгдсэн боловч барилгын гадна талыг шаардлага хангахгүй будгаар будсанаас гадна талын будаг борооны усанд урссан, халаалтын шугамыг буруу холбосноос паарнаас байнга ус гоождог,

А.2.2.3 Хэдийгээр стандартын шаардлага хангахгүй байгаа ч хуучин дотуур байрны барилгуудад их засвар хийх хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэн хүчин чадлыг нь нэмэгдүүлэн ашиглах хэрэгцээтэй байна. Үүнд:

- Буянт сумын 100 хүүхдийн дотуур байр 2010 онд ашиглалтад орсноос хойш хуучин 1981 онд ашиглалтад орсон 75 хүүхдийн хүчин чадалтай байрыг засвар хийгээгүйн улмаас ашиглахгүй, хөрөнгө оруулалт хийж ашиглах шаардлагатай,
- Зэрэг сумын сургуулийн дотуур байр нь 1967 онд ашиглалтад орсон цаашид ашиглах боломжгүй талаар МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлт гарсан, 100 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай байранд 2010 онд ашиглалтад орсон дунджаар 150-165 хүүхэд авч норм норматив мөрдөхгүй, эрүүл ахуйн байдал алдагдсан,
- Ховд сумын сургуулийн дотуур байранд 160 хүүхэд авах хүчин чадалтай дунджаар 200-210 хүүхэд байрлаж нэг өрөөнд 6-9 хүүхэд амьдарч байна.
- Мөст сумын сургуулийн 100 хүүхдийн хүчин чадалтай дотуур байр нь 2015 онд ашиглалтад орсон дээрээс ус гоождог, дээд давхрын өрөөнүүд маш хүйтэн, өвлийн улиралд өнцөг булан цан үүсдэг зэргээс шалтгаалан хүчин чадлаар бүрэн ашиглаж чадахгүй,

2017-2019 онуудад 13 барилгад их засвар хийгдэж 1 сургуулийн дотуур байр шинээр баригджээ.

А.2.2.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017-2019 онуудад 1148.2 сая төгрөгийн 13 их засварын ажил, 2500.0 сая төгрөгийн өртөгтэй 1 дотуур байр, урлаг, спортын заал, биеийн тамирын талбайн ажил, бүгд 3648.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгджээ.

2017 онд Булган сумын “Минжит Булган” цогцолбор сургуулийн засварт 110.7, Дарви сумын хичээлийн барилга 117.0, дотуур байрны засвар 88.4, Мөст сумын сургуулийн барилгын засвар 50.0, Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн сантехникийн засварт 29.1 бүгд 395.2 сая төгрөгөөр засвар хийгджээ.

2018 онд Жаргалант сумын 1 дүгээр сургууль 89.4, 2 дугаар сургууль 72.4, 7 дугаар сургууль 77.8, Мөнххайрхан сумын сургууль 113.7, Манхан сумын сургууль 30.0, Буянт сумын сургуулийн спортын заал 50.0 сая, бүгд 503.0 сая төгрөгийн их засвар ажлууд хийгдсэн байна.

2019 онд УТХО-аар Мөст сумын ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байранд 250.0 сая төгрөгөөр их засвар хийгдэж, Жаргалант сумын 7 дугаар сургуулийн дотуур байр, урлаг, спортын заал, биеийн тамирын талбайг 2018-2019 он дамжин 2500.0 сая төгрөгийн өртөгтэй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдаж 2019 онд ашиглалтад орсон байна.

А.2.2.5 Харин Жаргалант сумын ЦАЦ Сургуулийн 640 суудалтай хичээлийн байр, спорт заал, Алтай сумын сургуулийн өргөтгөлийн барилга шинээр барих, Дуут сумын сургуулийн спорт заал, Булган сумын 1 дүгээр сургуулийн спорт заалны засварын ажлууд 2019-2020 он дамжин хийгдэж байна.

А.2.2.6 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2019 онуудад хийгдсэн ажлуудыг тухайн онуудын УТХО-ын үр дүнд хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар албан шаардлага, зөвлөмж өгөгдсөн ч хэрэгжүүлсэн компаниуд дутуу ажлыг бүрэн гүйцэтгэхгүй зөрчил байсаар байна. Тухайлбал:

- УТХО-аар 2018 онд **“Ланз” ХХК-ны гүйцэтгэсэн Чандмань сумын сургуулийн Спорт заалны их засварын барилгын дээвэр, гадна ханануудын дээд хэсгээр ховхорч, холцруутсан, зарим хэсэгт хананы замаск, будаг цуурсан, цонхны хүрээг дутуу хийсэн,**
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд **“Энержи сэт” ХХК-ны Мөст сумын сургуулийн 100 хүүхдийн хүчин чадалтай дотуур байр нь 2015 онд ашиглалтад орсон ашиглалтын шаардлага хангахгүй талаар Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2020 оны 9 дүгээр сард 21-07/036/104 тоотой тус сумын дотуур байрны барилга нь “Барилгын тухай” хуулийн 11.1.5¹²-д заасан заалтуудыг зөрчигдөж байна гэсэн дүгнэлт гарсан. Мөн аймгийн Онцгой комиссын 2020 оны 21 тоот тогтоолоор сумын давсан орлогоос 90.0 сая төгрөгийг дотуур байранд засвар хийхээр сумын 2020 оны төсөвт тодотгол хийж ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байна.**
- Жаргалант сумын 7 дугаар сургуульд 2018 онд УТХО-аар Баруун Жонон ХХК 80.0 сая төгрөгөөр их засвар хийгдсэн ч дулааны алдагдал буураагүй байна.

А.2.2.7 Япон улсын өвсний үндэс хөтөлбөрийн санхүүжилтээр 2018 онд Буянт сумын сургуулийн хичээлийн байр, спорт заалны цонхны засвар 76.0, Булган сумын Минжит Булган цогцолбор сургуулийн дотуур байранд 194.0 сая төгрөгийн их засвар хийгдсэн нь үр дүнтэй хөрөнгө оруулалт болжээ.

Зарим сургуулиудын анги танхим хүрэлцэхгүйгээс нэгтгэн ашиглаж байгаа төдийгүй, сургалтын кабинетууд болон 6 настай хүүхдийн кабинетэд тавилга эд хогшил, хичээлийн хэрэглэгдэхүүн дутагдалтай байна.

¹² “барилга байгууламж нь ашиглалтын явцад хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулахгүй, галд тэсвэртэй, цахилгаан хангамж, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй байхаар төлөвлөгдөг баригдсан байх”

А.2.2.8 БСУГ-аас ирүүлсэн ЕБС-ийн сургалтын орчны судалгаагаар хими 72 хувь, физик 88 хувь, биологи 68 хувьтай тус тус хангагдсан, харин англи хэлний лингфоны кабинетаар 88 хувь нь хангагдаагүй байна. Лаборатори, кабинетуудад шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт дээрх кабинетуудын хувьд дунджаар 44 хувь нь бүрэн бус, 38 хувь нь хангагдаагүй байна. /Дүрслэл -3 Кабинет ашиглалт/



А.2.2.8 Зарим сургуулиудад анги танхимын хүрэлцээгүйгээс ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS 6782:2019 стандартын 6.5.1¹³ гэсэн заалтыг зөрчин анги, танхимыг хуваах, нэгтгэх, коридорыг анги болгон өөрчилсөн байна. Үүнд:

- Ховд сумын сургууль нь 320 хүүхэд сургах хүчин чадалтай бөгөөд 450-470 хүүхдийг 2 ээлжээр хичээллүүлэн анги танхимын хүрэлцээгээс хичээлийн барилгын 1, 2 дугаар давхрын коридорыг анги болгон өөрчилсөн,
- Жаргалант сумын 7 дугаар сургуулийн монгол хэлний кабинет, 207 дугаар өрөөг жижгийг томсгосон, 202 тоот ангийн шал нь стандарт бус, серверийн өрөөний ханыг буулгаж сунгасан, 107 тоот ангийг коридорын хэсэг модон рамтай хана хийж анги болгосон, 114 б анги стандарт бус гал тогооны заалнаас сунгасан,
- Жаргалант сумын 3,6 дугаар, Ховд сумын сургуулиудын барилга анх ашиглалтад орохдоо ОО зориулалттай баригдсан өрөөг эмчийн өрөө болгон өөрчлөн ашиглаж байгаа,

А.2.2.9 6 настай хүүхдүүдийн бие бялдрын онцлогт таарсан анги танхим ширээ, сандлаар хангагдсан, хүүхэд хөгжүүлэх стем хэрэглэгдэхүүнийг хичээлийн хөтөлбөрийн дагуу ашиглаж байгаа боловч зарим сургуулиудад хичээлийн жилүүдэд шинээр бүлэг нэмэгдсэнтэй холбоотой хүрэлцээний хувьд дутагдалтай байна.

А.2.2.10 БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтаар 2008 онд 6 настай хүүхдийн ширээ сандал, хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэгдэж, түүнээс хойш үе шаттайгаар дэлхийн Зөн ОУБ болон бусад төсөл хөтөлбөрүүдээр анги танхимуудад олгогдсоноос стандартын шаардлага бүрэн хангахгүй байгаа ширээ, сандал, хэрэглэгдэхүүнийг шинэчлэх, баяжилт хийх зайлшгүй хэрэгцээ байсаар байна.

А.2.2.11. ЕБС-ийн сургалтын орчны судалгаагаар бохирын болон ариутгах татуургын төвлөрсөн системд 9 сургууль холбогдсон, бусад 16 сургууль гадна бие засах жорлон ашиглаж байна.

Сургалтын орчны аюулгүй байдлыг сайжруулах талаар тодорхой ажил зохион байгуулж байгаа ч ЕБС-ийн орчны ерөнхий шаардлагын зарим заалтууд зөрчигдөж байна.

¹³ Барилгын төлөвлөлтийн норм, дүрмийн дагуу баригдсан өрөө, тасалгааны зориулалтыг өөрчлөхийг хориглоно.

А.2.2.11 Жаргалант сумын 2018 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын I, YI, Прогресс, ЦАЦС-ийн ойр орчмын аюулгүй байдлыг хангуулах зорилгоор хурд сааруулагчийг 14.9 сая төгрөгөөр “Ховд АЗЗА” ХХК гүйцэтгэсэн нь хүүхдийг замын хөдөлгөөний ослоос хамгаалах ач холбогдолтой ажил болжээ.

А.2.2.12 Эцэг эхчүүдийн төлөөллийг оролцуулан замын хөдөлгөөний “сургууль–цагдаа” арга хэмжээ зохион байгуулж байгаа нь үр дүнгээ өгч хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангагджээ..

А.2.2.13 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS 6782:2019 стандартын 5.2.5¹⁴ дахь заалтыг зөрчин Алтай, Буянт, Манхан, Мөнххайрхан, Зэрэг, Чандмань сумдын ерөнхий сургууль, Булган сумын Минжит Булган цогцолбор сургуулийн барилгын дээвэр дээр Мобиком, Юнитель, Жимобайл ХХК-ний антенныг байршуулан сар бүр түрээсийн орлого авч байна. Мөн Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS 6782:2019 стандартын 6.1.1¹⁵, 6.1.2¹⁶, 6.1.3¹⁷ дахь заалтууд бүрэн хангагдаагүй дараах зөрчлүүд байна.Үүнд:

- *Ховд сумын сургуулийн барилгын 1 дүгээр давхрын аваарын гарцын хаалганы дундуур халаалтын труба татсан, 2 дугаар давхрын гарцыг битүүлсэн,*
- *Цэцэг сумын сургуулийн дотуур байрны ойролцоо гүний худагтай гаднах хашаа хайс хамгаалалт нь шаардлага хангахгүй байрны хүүхдүүдийн аюулгүй байдал алдагдсан,*
- *Ховд сумын сургуулийн хашаанд дотуур байрны гадна байрлах хүнсний ногооны зоорины дээвэр нь цөмөрсөн хүүхэд унаж бэртэх нөхцөл үүссэн,*
- *Жаргалант сумын 3 дугаар сургуулийн ойр орчинд сүүлийн жилүүдэд орон сууцны зориулалттай барилга хийх хэмжээгээр баригдаж сургуулийн эргэн тойронд барилгын хог хаягдал их хэмжээгээр бий болсон,*
- *Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн эдэлбэр газрыг аймгийн Засаг даргын 2019 оны А/230 тоот захирамжаар газрын ашиглалтын зориулалтыг өөрчилсөн нь Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5¹⁸, 42.7¹⁹, 42.8²⁰ дахь заалтуудыг зөрчсөн,*
- *Чандмань сумын сургуулийн эзэмшлийн талбайд сумын нийтийн халуун усны барилгын ажил хийгдэж сургуулийн хашааны хэсэг, хашаа, хайс онгорхой мөн нэгдсэн дулааны шугамын холболт явагдаж байгаа нь хүүхдийн аюулгүй байдал алдагдсан,*
- *Зэрэг сумын сургуулийн эзэмшлийн газарт баригдсан хуучин гал тогоог дуудлага худалдаагаар борлуулснаас газарт бусдад шилжих эрсдэл үүссэн,*
- *Зэрэг сумын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй эцэг эх, сурагчид орох гарах гарц байхгүй, шинээр баригдаж байгаа хашаа нь стандартын дагуу хийгдээгүй, шовх үзүүрүүд ил байгаа нь хүүхдийн аюулгүй байдалд эрсдэл үүссэн,*

А.2.2.14 MNS 6782:2019 стандартад эзэмшил газарт ногоон байгууламж, сургалт туршилтын талбай нийт талбайн 25 хувиас доошгүй байхаар заасан ч зарим сургуулиуд ногоон байгууламж хийх газар байхгүй, төсөв хүрэлцэхгүй, сургуулийн удирдлагуудын

¹⁴ “сургуулийн барилгын дээвэр болон сургуулийн харилцаа холбооны антен, тоног төхөөрөмж байрлуулахыг хориглосон”

¹⁵ Сургуулийн барилга байгууламжийн аюулгүйн гарц нь аюулт үзэгдлийн үед ашиглахад бэлэн байна.

¹⁶ Аюул, аваар осол гарсан үед барилгаас гарах урсгал хөдөлгөөнийг харуулсан зураг, схем, аваарын гэрэл, дохио тэмдэглэгээг гарц бүрд байршуулна.

¹⁷ Гарцын тэмдэглэгээг харанхуйд гэрэлтүүлнэ

¹⁸ “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, эдэлбэр газрыг зориулалтын дагуу ашиглана”

¹⁹ 42.7.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь шинээр барих сургууль, цэцэрлэгийн урт хугацааны төлөвлөлтийг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж, сургууль, цэцэрлэгийн эзэмшил, ашиглалтын эдэлбэр газрыг сургалтын орчинд тавигдах шаардлагад нийцсэн талбайн хэмжээний дагуу нөөцөд авах шийдвэр гаргана.

²⁰ 42.8.Энэ хуулийн 42.7-д заасны дагуу шинээр барих сургууль, цэцэрлэгийн нөөцийн газрыг өөр зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулах, худалдахыг хориглоно.

санаачилгагүй байдал зэргээс шалтгаалан ногоон байгууламж хийгдэхгүй байна Харин Булган сумын 1,2 дугаар сургууль, Жаргалант сумын 1,7 дугаар сургуулийн ногоон байгууламж жилээс жилд нэмэгдэж байгаа нь бусад сургуулиудад жишиг болохуйц сургалтын гаднах таатай орчин бүрдсэн байна.

А.2.2.15. ЕБС-ийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS 6782:2019 стандартын 8.1²¹, 8.2²² заасны дагуу аймаг, сумдын сургуулиуд улирал тутам эрсдэлийн үнэлгээ хийгээгүй байна.

Салбарын яамны хөрөнгө оруулалтаар хуваарилагдан ирсэн хөрөнгийн талаарх судалгаа хангалтгүй байна.

А.2.2.16 Аймгийн сургуулиудын сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2018 онд 95.3 сая төгрөгийн бага, дунд бүлгийн 615 ширээ, 1230 сандал Буянт тэгш үйлс ХХК үйлдвэрлэж 17 сумын 24 сургуулиудад олгожээ. 2019 онд ОНХО-аар 47.3 сая төгрөгийн ширээ сандлыг Улаанбүрд ХХК нийлүүлж, сургуулиудад хуваарилсан байна.

А.2.2.17 Аймгийн БСУГ-ын эдийн засагчийн ирүүлсэн мэдээллээр 2017 онд 88.5 сая төгрөг, 2018 онд БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтын программ цахим халдлагад өртөж мэдээллийн бааз устсан, 2019 онд 265.1 сая төгрөгийн хөрөнгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар БСШУСЯ-аас олгосон ч жил бүр хуваарилагдан ирсэн хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй судалгаа, мэдээлэлгүй байна. Энэ нь аймгийн БСУГ-ын эдийн засагч, эд хариуцагчийг тогтвор суурьшилтай ажиллуулдаггүй аймаг сумдад олгосон хөрөнгийн анхан шатны болон холбогдох материалыг бүрэн бүрдүүлдэггүй, нөгөөтээгүүр БСШУЯ-аас хөрөнгийг сургуулиудад шууд нийлүүлж байгаатай холбоотой байна.

А.2.2.18. ЕБС-ийн сургалтын орчны судалгаагаар сургуулийн суралцагчдыг тээвэрлэх автобусгүй байна.


Сургуулийн барилга нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг зорчих шаардлага хангагдахгүй байна.

А.2.2.19 Аймгийн хэмжээний ЕБС-ууд 2016-2017 онд 271, 2017-2018 онд 232, 2018-2019 онд 179 хараа, сонсгол, хэл яриа, оюун ухааны, бие эрхтний болон хавсарсан хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч байгаагаас Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл

мэнд, нийгмийн хамгааллын салбар комиссын дүгнэлттэй 89 хүүхэд суралцаж байна.

/Дүрслэл – 4 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаа/

А.2.2.20 Жаргалант сумын 12 жилийн 7 дугаар сургууль



²¹ Сургуулийн дотоод хяналтын зөвлөл, сурагчдын өөрийн удирдлагын байгууллага болон эцэг эх, асран хамгаалагчдын зөвлөл хамтран сургуулийн гадаад орчны аюулгүй байдлын зураглал гарган эрсдэлийн үнэлгээг улирал тутам хийж эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ

²² Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагад хандаж эрсдэлийн үнэлгээ хийлгэнэ

“Хөгжлийн бэрхшээл -Хөгжих саад биш” төслийг Жайка олон улсын байгууллагатай хамтран тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах зорилгоор хэрэгжүүлжээ. Төсөлд хүнд хэлбэрийн 5, хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй 20 нийт 25 сурагчийг дугуйлан секцэд хамруулж, сэтгэхүй хөгжүүлэх сургалт сурагчдыг чадваржуулах цаг гэсэн 4 чиглэлийн дагуу үйл ажиллагаагаа явуулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах талаар БСШУС-ын сайдын 2019 оны А/292 тушаалаар баталсан журмын 2 дугаар хавсралтад заасан “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим”-д байвал зохих хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслүүдээр хангагдаагүй, хүүхдийн хөгжлийг дэмжих танхимуудыг сумдын сургуулиудад байгуулах шаардлагатай байна.

Дээрхээс шалтгаалан харах, сонсох, хэл ярианы бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд тохирох ном, сурах бичиг, гарын авлага, брайль үсэг, дохионы хэл болон харилцааны бусад арга хэлбэрийг хэрэглэх материал, тоног төхөөрөмжгүйгээс хүүхдийн хөгжилд ахиц өөрчлөлт гаргаагүй байна.

А.2.2.21. ЕБС-ийн сургалтын орчны судалгаагаар сургуулийн барилга нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн зорчих стандартын шаардлагыг бүрэн хангасан 1, бусад 24 сургууль шаардлага хангахгүй байна.

Хүүхэдтэй холбоотой гэмт хэрэг зөрчил жилээс жилд нэмэгдэж байхад сургалтын орчныг хяналтын камерар бүрэн хангах шаардлагатай байна.

А.2.2.22 БСШУСЯ-ны сайдын А/239 тоот тушаалд заасны дагуу сургуулийн сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журмын 3.4.1²³ дэх, ЕБС-ын орчны аюулгүй байдал ерөнхий шаардлага MNS 6782:2019 стандартын 5.7.1²⁴, 5.7.2²⁵, 5.7.3²⁶, 6.5.2²⁷-д заасны дагуу аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн болон дотуур байранд хяналтын камер байрлуулсан ч ашиглах, бичлэг хадгалах, хянах дүрэм журам боловсруулан мөрдөн ажиллаагүй, хяналтын камерууд нь бичлэгээ 7-30 хоног хадгалдаг байна. Үүнд:

- Дөргөн, Зэрэг сумын сургуулийн хичээлийн болон дотуур байранд хяналтын камергүй,
- Эрдэнэбүрэн сумын сургуульд ашиглаж байгаа хяналтын камер нь гадна орчныг харах боломжгүй,
- Ховд сумын сургууль болон дотуур байранд 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хяналтын камерын ажлыг одоог хүртэл хүлээлгэн өгөөгүй, дотуур байрны камер бүдээ,
- Цэцэг сумын хичээлийн байр хяналтын камергүй, дотуур байрны хяналтын камерыг 2018 онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн боловч 30 минут ажиллаад төхөөрөмж нь халаад унтарчихдаг, бичлэг хадгалагдаж байгааг хянах боломжгүй,
- Чандмань сумын хяналтын камер нь коридор хэсгийг хардаг, гадна орчныг харах боломжгүй,
- Жаргалант сумын 6 дугаар сургуулийн хяналтын камер нь сургуулийн доторх орчныг бүрэн харах боломжгүй зөвхөн 1 талын жигүүрийг хянадаг,

²³ Цэцэрлэг, сургууль, дотуур байрыг хяналтын камертай болгон түүнийг ашиглах, бичлэг хадгалах, хянах, дүрэм, журам батлан мөрдүүлнэ

²⁴ Сургуулийн гадна орчныг бүхэлд нь хянах боломжтой MNS 6423 стандартын шаардлага хангасан хяналтын камер байршуулсан байна. Хяналтын камер нь: - харанхуй, үзэгдэх орчин хязгаарлагдсан үед бичлэг хийх чадвартай, - хүний зүс царай, гадаад дүр төрх, содон шинж тэмдгийг татаж томруулах боломжтой байх

²⁵ Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангана

²⁶ Дүрс бичлэгийг 1 сараас доошгүй хугацаанд хадгалж архивлана

²⁷ Сургуулийн дотоод орчны эрсдэлтэй хэсэгт хяналтын камер суурилуулна.

А.2.2.23 Мөн журмын 3.5.4²⁸ дахь заалтын дагуу сургуулиуд хүүхэд хамгааллын талаарх дүрмээ боловсруулан баталсан ч, 6.2²⁹, 6.3³⁰ дахь заалтуудын хэрэгжилтийг ханган ажилласан нь тодорхой бус, аймгийн БСУГ-ын жил бүрийн үйл ажиллагааны тайланд энэ талаар тусгаагүйгээс харахад хэрэгжилт хангалтгүй байна.

А.2.2.24 БСШУСЯ-ны 2018 оны А/476 тоот тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого”-ын журамд заасны дагуу сургуулиуд хүүхэд хамгааллын талаар сургуулийн болон орон нутагт орон тооны бус зөвлөлөө байгуулж хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан мөрдөж байгаа ч Зэрэг, Ховд, Чандмань, Эрдэнэбүрэн сумын сургуулиуд дүрмээ боловсруулаагүй байна.



А.2.2.25 Хүүхэд хамгааллын талаар Жаргалант сумын 3 дугаар сургууль “5 гаригт 5 минут” хөтөлбөр хэрэгжүүлэн, хөтөлбөрөөр бүх ангиудын сурагчдад гариг бүрийн сүүлийн хичээл орж байгаа багш 5 минутын мэдээллийг өгч хэвшсэн байна. /Зураг 1-сайн туршлага/

А.2.2.26 Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн мэдээгээр хүүхдийн тусламж 108 утсанд 2017 онд 53, 2018 онд 79, 2019 онд 61 дуудлага иржээ. Ирсэн дуудлагыг хэлбэрээр нь авч үзвэл: бие махбод 17, бэлгийн хүчирхийлэл 5, үл хайхрах 31, сэтгэл санааны 8, орчноор авч үзвэл гэр бүлийн орчинд 45, боловсролын орчинд 9, олон нийтийн орчинд чиглэлээр ирсэн байна. 2019 онд 108 утсанд ирсэн дуудлагыг өмнөх онтой харьцуулахад 18 буюу 22.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. /Дүрслэл -5 Хүүхдийн 108 утасны дуудлага/

Үзүүлэлт	2016- 2017 оны хичээлийн жилд	2017-2018 оны хичээлийн жилд	2018-2019 оны хичээлийн жилд
Захирал	25	25	26
Сургалтын менежер	57	57	57
Нийгмийн ажилтан	25	25	25
Үндсэн багш	1006	1021	1029
Албан бус боловсролын багш	5	6	8
Бусад	688	672	661
БҮГД	1806	1806	1806
Захирал, сургалтын менежер болон багш	60.5	61.4	62.0

А.2.2.27 Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээллээр 2019 онд насан хүрээгүй хүүхэд оролцсон 51 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 29 хэргээр буюу 3 дахин, гэмт хэрэгт холбогдсон 80 хүүхэд бүртгэгдэж 8.1 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хуулийн байгууллагаас ирүүлсэн тоо мэдээгээр Жаргалант сумын I, II, III, VI, VII, ЦАЦСургуулиуд 2019 онд гарсан нийт гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо 41 буюу 51.2 хувь, 24 буюу 30 хувийг сургууль завсардсан болог сурдаггүй хүүхдүүд эзэлж байна.

Хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн олголтын талаарх нэгдсэн судалгааг боловсронгуй болгох шаардлагатай байна.

²⁸ Цэцэрлэг, сургууль бүр хүүхэд хамгааллын бодлогод нийцүүлэн “Хүүхэд хамгааллын дүрэм”-ийг баталж мөрдөнө

²⁹ Үйл ажиллагааны тайланг цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал хичээлийн жилийн төгсгөлд хамт олон, эцэг эх, сургуулийн зөвлөлд танилцуулж, жил бүрийн 05 дугаар сарын 20-ны дотор аймаг нийслэлийн боловсролын газарт хүргүүлнэ

³⁰ Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс нь журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээг жил бүр хийж, үр дүн бүхий тайланг 6 дугаар сарын 1-ний дотор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ


А.2.2.28 БСШУ Спортын яамнаас 2019 онд Буянт, Зэрэг, Дөргөн, Жаргалант сумын 1, 2, 6 дугаар сургуулиудад химийн, Булган сумын 2, Дарви, Мянгад, Мөст, Эрдэнэбүрэн, Жаргалант сумын 1,6 дугаар сургуулиудад физикийн, Цэцэг, Чандмань сумдын сургуульд дизайн технологийн, 16 сумдын сургууль, Ховд их сургуулийн харьяа лицей ахлах сургуулиудад 25 математикийн багц кабинетын тоног төхөөрөмж, Булган сумын 2, Буянт, Дарви, Дөргөн, Мянгад, Мөст, Цэцэг, Чандмань, Эрдэнэбүрэн сумдын сургууль, Жаргалант сумын 1,2, 3, 6 дугаар сургуульд документ камеруудыг хуваарилжээ.

А.2.2.29 Аймгийн БСУГ-т сумдын ЕБС-иудад шаардлагатай тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг нэр төрөл, тоо ширхгээр эдийн засагч нь судалгааг гарган ирүүлсэн боловч тухайн хичээлийн жилүүдэд БСШУСЯ болон бусад төсөл хөтөлбөрөөр хангагдаж байгааг тулган баталгаажуулаагүй, нэгтгэсэн судалгааг боловсронгуй болгох шаардлагатай байна.

ЗАРИМ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧИН АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТОД ЗААСАН ШАЛГУУР НӨХЦӨЛИЙГ ХАНГААГҮЙ, МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТАД ХАМРАГДСАН БАГШИЙН СУДАЛГААГҮЙ БАЙНА.

Сургуулиуд мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан, мэргэжлийн номын санчаар бүрэн хангагдаагүй байна.

А.2.3.1 Аймгийн хэмжээнд 27 сургуульд 1806 багш, боловсролын үйлчилгээний ажилчид ажиллаж сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж байгаагаас нийт ажилчдын 2017 онд 60.5, 2018 онд 61.4, 2019 онд 62.0 хувийг захирал, сургалтын менежер, багш нар эзэлж байна. /Хүснэгт -2 ЕБС-ийн нийт ажилчдын судалгаа/




А.2.3.2 БСШУС-ын сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 тоот “орон тооны жишиг норматив батлах тухай” тушаалын 2³¹-д заасны дагуу Мөнххайрхан сумын сургууль, Жаргалант сумын 1, 6 дугаар сургуулиуд хичээл зохицуулагч, Булган сумын 1 дүгээр сургууль нь номын санч 2 ажиллаж байна.

А.2.3.3 Аймгийн хэмжээний ЕБС-д 24 номын санч ажиллаж байгаагаас Булган сумын 1, Манхан, Мянгад, Жаргалант сумын 1, 3, Цаст алтай цогцолбор сургуулийн номын санч мэргэжилтэй Соёлын дээд сургуулийн “номын сан судлал, мэдээлэл” гэсэн мэргэжлээр төгссөн 7 буюу 29.2 хувь нь номын санч, 13 буюу 54.2 хувь нь багш мэргэжилтэй, 2 буюу 8.3 хувь нь солонгос, хятад хэлний орчуулагч, бусад 2 буюу 8.3 хувийг тус тус эзэлж байна. Тухайлбал: Дуут сумын номын санч Солонгос хэлний орчуулагч, Жаргалант сумын Прогресс сургууль хятад хэлний орчуулагч, Жаргалант сумын 2 дугаар сургуулийн номын санч бүрэн дунд боловсролтой, Дөргөн сумын сургуулийн номын санч нийгмийн ажилтан нар тус тус ажиллаж байна. Чандмань сумын номын санчийг бичээч хавсран гүйцэтгэж байна.

³¹ Ерөнхий боловсролын 1-12 дугаар ангитай 1501-ээс дээш сурагчидтай сургуульд хичээл зохицуулагч 1

А.2.3.4 Зөвлөх, тэргүүлэх, арга зүйч мэргэжлийн зэрэгтэй багш нар нийт багшийн 2017 онд 60.7, 2018 онд 67 хувь, 2019 онд 51.5 хувийг, боловсролын түвшингээр доктор 0.1, магистр 15.1-16.5, бакалавр 65.6-68.3, дипломын 8.4-9.7, бусад 0.1-1.6 хувийг тус тус эзэлж байна.

А.2.3.5 ЕБС-иуд ажиллаж байгаа нийт багш нарыг боловсролын түвшин, мэргэжлийн зэргээр ангилан харуулбал: /Дүрслэл–6 Багш нарын мэргэжлийн зэрэг, боловсролын түвшний судалгаа/



Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд мэргэжил дээшлүүлсэн багш нарын нэгдсэн болон дэлгэрэнгүй судалгаа байхгүй байна.

А.2.3.6 Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 9.4³² дэхь болон Боловсролын тухай хуулийн 40.8³³- д заасны дагуу 1,5,10 дахь жилдээ ажиллаж буй багш нарыг 2017 онд 160, 2018 онд 160, 2019 онд 94 багш Удирдлагын академийн БМДИ-ийн төвлөрсөн сургалтад хамрагдсан гэж аймгийн БСУГ-ын жилүүдийн тайланд тусгасан ч багш бүрээр гаргасан дэлгэрэнгүй судалгаагүй байна.

Боловсролын салбарын “Удирдлагын мэдээллийн цахим систем”-д багш нарыг үндэсний, орон нутгийн болон төрөлжсөн, ажлын байран дахь сургалтад хамруулсан тухай статистик мэдээг Захиргааны статистикийн мэдээлэл, Маягт БДБ-10-д нэгтгэсэн мэдээлэл нь БСУГ-ын 2017-2019 оны үйл ажиллагааны тайлан дахь тоо мэдээлэлтэй зөрүүтэй байна. Үүний гол шалтгаан нь сургалтад хамрагдсан багшийн мэдээллийг бүрэн оруулаагүйгээс тухайн онуудад хэчнээн багш нар сургалтад хамрагдсаныг нотлох боломжгүй байна.

А.2.3.7 Аймгийн хэмжээний ерөнхий боловсролын сургуульд Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 7.1³⁴-д заасны дагуу 24 багш хөгжлийн төвийг ашиглаж байгаа ч тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй, хуулийн 7.3³⁵-д тухайн байгууллагын хувьсах зардлын 2 хүртэл хувийг багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд зарцуулахаар заасан заалтыг аймгийн хэмжээнд мөрдөөгүй байна.

А.2.3.8 БСШУСЯ-ны сайдын А/692 тоотойр ЕБС-ийн захирал, сургалтын менежерийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, үндсэн чиг үүргийг баталсан байна. Зарим сургуулийн

³² Багшийг хөгжүүлэх үйл ажиллагаа нь багш мэргэжил эзэмшсэн хугацаанаас тооцогдох бөгөөд Боловсролын тухай хуулийн 40.8 дахь хэсэгт заасан багшийн мэргэжлийг дээшлүүлэх сургалтад хамрагдах үндэслэл болно.

³³ Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн мэргэжлийг өмчийн хэлбэр үл харгалзан улсын төсвийн хөрөнгөөр 5 жил тутам дээшлүүлнэ

³⁴ Бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь багшийн хөгжлийн төвтэй байна

³⁵ Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын нийт хувьсах зардлын 2 хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулна.

захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтнууд уг тушаалд заасан мэргэшил, туршлагад тавигдсан шаардлагыг хангаагүй байна. Үүнд:

- Дуут, Зэрэг, Мөст, Чандмань, Жаргалант сумын 3, Цаст алтай цогцолбор, сургуулиудын захирал нь А/692 тоот тушаалын 1 дүгээр хавсралтад заасан мэргэшил³⁶ дахь шалгуур нөхцөлийг хангаагүй,
- Мөнххайрхан, Чандмань, Үенч, Жаргалант сумын 1, 3, Цаст алтай цогцолбор сургуулийн захирлууд 1 дүгээр хавсралтын туршлага³⁷ дахь заалтыг зөрчсөн,,
- Алтай, Булган сумын 1, Булган сумын 2 дугаар, Зэрэг, Мянгад, Мөст, Мөнххайрхан, Чандмань, Эрдэнэбүрэн сумд болон Жаргалант сумын Прогресс сургуулийн сургалтын менежерүүд нь тушаалын 2 дугаар хавсралтад заасан мэргэшил³⁸ нөхцөлийг бүрэн хангаагүй,

А.2.3.9 ЕБС-д 25 нийгмийн ажилтан ажиллаж байгаагаас 18 буюу 72 хувь нь нийгмийн ажилтан, 7 буюу 28 хувь нь багш мэргэжилтэй ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэшил³⁹ заасан шалгуур нөхцөлийг хангаагүй байна. Үүнд: Алтай сум дуу хөгжим, Дарви сум биологи, Мянгад сум монгол хэл уран зохиол, Чандмань сум физик, Эрдэнэбүрэн сум газар зүйн багш мэргэжилтэй байна.

А.2.3.10 Булган сумын 2 дугаар сургууль нь БСШУСпортын сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 тоот “орон тооны жишиг норматив батлах тухай” тушаалын 2⁴⁰-д заасныг мөрдөөгүй ерөнхий менежер гэсэн орон тоог нэмэгдүүлэн ажиллаж байна.

А.2.3.11 2017-2019 онуудад захирлуудын сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа БСШУСС-ын баталсан ажлын байрны тодорхойлолтыг үл харгалзан тухайн томилогдох албан тушаалтны ажлын туршлагад тохируулан өөрчилдөг дутагдал нийтлэг байна. Тухайлбал:

- БСШУСС-ын 2007 оны 351 тоот тушаалын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтод тусгагдсан шаардлагад бакалавраас доошгүй зэрэгтэй, боловсролын зэргээр мэргэшсэн, багшлах ба боловсролын удирдлагаар хосолсон дадлага туршлагатай байх гэсэн шаардлагыг хангаагүй төрийн албан хаагчийг Цаст-алтай цогцолбор сургууль, Жаргалант сумын 6 дугаар сургуулиудын захирлын албан тушаалд томилсон байна.
- Аудитын явцад сонгон шалгаруулалтад оролцсон захирлуудын материалыг БСУГ-аас шаардан авахад ирүүлсэн материалаас дүгнэлт хийх боломжгүй байна.
- Бүх сумдын ЕБС-ууд нь багш нарын сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасны дагуу сонгон шалгаруулалтыг 2017-2019 онуудад зохион байгуулсан ч шалгалтад хамрагдсан багш нарын холбогдох материалуудыг цэгцэлж архивын нэгж үүсгээгүй байна.

А.2.3.12 Түүвэрт хамрагдсан сургуулиудаас Жаргалант сумын VII, VI, II, Чандмань, Мөст сумын сургуулиуд Засгийн газрын 311 дүгээр тогтоолын дагуу сургуулийн захирлын дэргэд дотоод хяналтын баг томилогдон ажиллаж дотоод хяналтын үнэлгээг хийж эрсдэлээ тодорхойлон авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан байна.

³⁶ Боловсрол, нийгэм, төрийн удирдлага, боловсрол судлалын аль нэг чиглэлээр мэргэшсэн байх

³⁷ 3-аас доошгүй жил ЕБС-д удирдах албан тушаалд эсхүл боловсролын салбарын байгууллагад удирдах болон гүйцэтгэх албан тушаалд ажилласан байх

³⁸ Боловсрол, нийгэм, төрийн удирдлага, боловсрол судлалын аль нэг чиглэлээр мэргэшсэн байх

³⁹ Нийгмийн ажил, нийгмийн удирдлага

⁴⁰ Ерөнхий боловсролын 1-12 дугаар ангитай 960 суралцагчтай сургуульд сургалтын менежер 3 ажиллах

ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ БОДИТОЙ БУС, ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ, ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ СУЛ, ТӨСӨВ ХЭМНЭХ БОЛОМЖИЙГ АЛДАЖ БАЙНА.

Хувьсах зардлыг тооцох тогтоолыг шинэчлээгүй, хэрхэн хуваарилах талаар аргачлал байхгүйгээс төлөвлөлт алдаатай төлөвлөгдөж, сургуулиудын нормативт зардлын хэмнэлтийг бусад хүрэлцэхгүй зардалд гүйлгэн зарцуулж байна.

Засгийн газраас 2018, 2019 онуудад цалин нэмэх шийдвэрийг гаргасан боловч хувьсах зардал тооцох 2016 оны 242 тоот тогтоолыг өөрчлөөгүй, бусад хувьсах зардлыг хэрхэн хуваарилах талаар аргачлал байхгүйгээс төлөвлөлт алдаатай төлөвлөгдөж байна.

А.3.1.1 Ховд аймгийн боловсрол, соёл, урлагийн газар нь ерөнхий боловсролын сургуулийн хувьсах зардлыг ЗГ-ын 2016 оны 242 тоот тогтоолын дагуу өмнөх жилийн хүүхдийн тоонд үндэслэн төлөвлөж, аймгийн 24 сургууль, 2 насан туршийн боловсролын төв, 1 лицей сургуульд 2017 онд 24002.4 сая төгрөг, 2018 онд 23597.4 сая төгрөг, 2019 онд 24292.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталжээ. /Дүрслэл-7 2017-2019 оны батлагдсан төсөв/



А.3.1.2 2017 онд аймгийн БСУГ-аас өгсөн төсвийн төслийг 434.3, 2018 онд 528.6, 2019 онд 455.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ. 2017 онд тогтмол зардлыг 195.6, хоолны зардлыг 283.6, үдийн цайны зардлыг 49.0, хувийн хэвшилд олгох татаас 8.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн цалин хөлсний зардлыг 92.3, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 10.2 сая төгрөгөөр бууруулжээ.

А.3.1.3 2018 онд тогтмол зардлыг 326.0, хоолны зардлыг 281.6, нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 10.2, тэтгэвэрт гаргахад олгох тэтгэмжийг 2.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн цалингийн зардлыг 74.0, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 10.2, үдийн цайны зардлыг 7.7 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

А.3.1.4 2019 онд цалингийн зардлыг 243.8, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 30.5 сая, хоолны зардлыг 264.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлыг 62.4, хувийн хэвшилд олгох татаас 21.1 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

А.3.1.5 Боловсролын тухай хуулийн 40.3⁴¹-д заасны дагуу нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлыг 2016 оноос хойш шинэчлээгүй байгаагаас хувьсах зардлаар төсвийг төлөвлөхөд 1 хүүхдэд ногдох хувьсах зардал нь сургуулийн бичиг хэрэг болон хичээл үйлдвэрлэлийн дадлагын материал худалдан авахад хүрэлцэхгүй байна.

⁴¹ Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно.

Төсвийг сургуулиудад хүүхдийн тоонд үндэслэхгүйгээр харилцан адилгүй хуваарилжээ.

А.3.1.6 2017, 2018 онд батлагдсан төсвийг хуваарилахдаа хүүхдийн тоонд үндэслэн хувьсах зардлыг хуваарилаагүй байна. ЗГ-ын 2016 оны 242 тоот тогтоолыг зөрчин сумдад илүү, дутуу санхүүжилтийг олгожээ. Тухайлбал:

- 2017 онд Зэрэг сумын сургуульд 10.3 сая төгрөгөөр илүү, 2018 онд 8.6 сая төгрөгөөр илүү хуваарилсан,
- 2018 онд Жаргалант сумын 1 дүгээр сургуульд 28.5 сая төгрөгөөр бусад хувьсах зардлыг илүү хуваарилсан,
- 2017 онд Үенч сумын сургуульд 12.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан,
- Чандмань сумын сургуульд 5.5 сая төгрөгийн БҮТЭЗ худалдан авахаар батлагдаж бусад хувьсах зардлыг 7.1 сая төгрөгөөр хэтрүүлэн хуваарилсан,
- Эрдэнэбүрэн сумын сургуульд 7.5 сая төгрөгөөр илүү хуваарилсан.
- 2017 онд Булган сумын 1 дүгээр сургуульд 1.0, 2-р сургуульд 1.2 сая төгрөгийн хувьсах зардлыг дутуу хуваарилжээ.

А.3.1.7 ЗГ-аас 2016 оны 242 тоот тогтоолыг шинэчлэн батлаагүй, уг зардлыг хэрхэн хуваарилах талаар аргачлалгүйгээс хуваарилсан бусад хувьсах зардлуудын зарим нь сургуулийн хэвийн үйл ажиллагааг хангахад хүрэлцэхгүй байна. Тухайлбал:

- Хөдөөгийн сумдын 17 сургуульд сард дунджаар бичиг хэргийн зардалд сард 41.0, шуудан холбооны зардалд 52.4 мянган төгрөг ногдож байна. Энэ нь сургуулийн орчинд интернэт хэрэглэх ямар ч боломжгүй, сард 1 принтерийн хор авахад хүрэлцэхгүй,
- Эмийн зардал 1 сургуульд сард дунджаар 30,0 мянган төгрөг ногдож байгаа нь сургуульд сурч буй 18.0 мянга гаруй хүүхдэд хүрэлцэхгүй,
- Урсгал засварын зардалд сард дунджаар 200.0 мянган төгрөг байгаа нь сургууль болон дотуур байр, спорт заалны засварын материалд хүрэлцэхгүй,
- 1 сургуульд сард дунджаар 41.0 мянган төгрөгийн томилолтын зардал ногдож байгаагаас хөдөөгийн сумдын багш нар мэргэжлийн олимпиад болон тэмцээн, уралдаанд оролцоходоо томилолтын мөнгөө авч чаддаггүй,
- 2017 онд Прогресс сургуульд урсгал засварын зардалд жилд 43.2 мянган төгрөг хуваарилсан нь нэг цонх хагарах, хэдэн гэрэл шатахад зэргийг худалдан авахад ч хүрэлцэхгүй,
- Жаргалант сумын 1 дүгээр сургууль нь ЗГ-ын 2012 оны 179 дүгээр тогтоолын 4⁴²-д заасан нэмэгдлийг цалингийн сан хүрэлцэхгүй байгаагаас бүрэн олгоогүй сард 5-15 хувиар цалингийн сандаа багтаан олгож иржээ.

Дотуур байрны хүүхдийн хоолыг хүүхдийн тоонд үндэслэн олгоогүйгээс хэмнэгдсэн зардлыг бусад зардалд гүйлгэн зарцуулжээ.

⁴² Ерөнхий боловсролын лаборатори сургуульд ажиллагчдад олгох нэмэгдлийг Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл"-д хамаарах ажилтнуудад сарын үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх, мөн тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын ангилал, зэрэглэл"-д хамаарах ажилтнуудад сарын үндсэн цалингийн 15 хувьтай тэнцэх хэмжээтэй байхаар тогтоож, 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсүгэй.

А.3.1.7 ЗГ-ын 2016 оны 242 тоот тогтоолоор дотуур байранд амьдарч буй хүүхдийн хувьсах зардлыг тооцоход 6 настай хүүхдэд ногдох цалингийн хувьсах зардлыг 402.8 мянган төгрөг буюу бусад хүүхдээс 134.6 мянган төгрөгөөр илүү байхаар тогтоожээ. 2018, 2019 онуудад цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор цалингийн зардлыг нэмэгдүүлээгүй байна. 6 настай хүүхдийг 2017 онд 34, 2018 онд 23, 2019 онд 10 хүүхдээр илүү төлөвлөн санхүүжилтийг олгосон байна. /Дүрслэл -8 Дотуур байранд амьдарч байгаа 6 настай хүүхдийн тоо/



2017 онд хүүхдийн хоолны зардалд 1330.0, 2018 онд 1330.0, 2019 онд 1336.2 сая төгрөгийн төсөв батлагджээ.

А.3.1.8 Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 17 дотуур байрнаас 11 дотуур байрыг түүвэрт хамруулан хянахад 2017 онд 614.7, 2018 онд 617.7 сая төгрөгийн хүүхдийн хоолны зардлын төсөв батлагджээ. Хүүхэд өдрөөр хяналт тавьж ажиллаагүйгээс хүүхдийн хоолны зардлыг батлагдсан сар улирлын хуваарийн дагуу олгож байгаагаас хоолны зардлыг илүү зарцуулж байна. Тухайлбал:

- Сангийн яамнаас төсвийг батлахдаа хүүхдийн хоолны зардлыг жил бүр үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн баталж байна. 2017 онд 283.6, 2018 онд 281.6, 2019 онд 264.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталж бусад зардалд гүйлгэн зарцуулсан,
- 2017 онд батлагдсан төсвөөс 57.6 сая, 2018 онд 78.4 сая төгрөгийг хэмнэж хэмнэгдсэн зардлыг төсөвт төвлөрүүлэхгүйгээр бусад зардалд гүйлгэн зарцуулсан
- Дотуур байрны хүүхдийн гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянахад 2017 онд 26.6, 2018 онд 26.4 сая төгрөгөөр хоолны зардлыг илүү зарцуулсан,
- 2018 онд Алтай сумын сургуулийн дотуур байранд 17786 хүүхэд байрлаж 7.8 сая төгрөгөөр, 2017 онд Мянгад сумын сургуулийн дотуур байранд 21052 хүүхэд байрлаж 10.3 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан,
- Манхан, Дуут, Зэрэг, Үенч сумдын сургуулиас бусад сургуулиуд хоолны зардлыг 2017 онд 1.5-6.6 сая төгрөгөөр, 2018 онд Дуут, Мөст, Үенч сумдын сургуулиас бусад сургуулиуд 5.9- 2.0 сая төгрөгөөр зардлыг хэтрүүлэн зарцуулсан,
- Эрдэнэбүрэн сумын сургууль нь дотуур байрны хүүхдийн бүртгэлгүйгээс хоолны толонд бичигдсэн хүүхдийн тоо үнэн зөв эсэхийг хянах боломжгүй байна.

Тараах материал, сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авах төсөв хүрэлцэхгүй байна.

А.3.1.9 ЗГ-ын 2016 оны 242 тоот тогтоолд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа 1 хүүхдэд ногдох бусад хувьсах зардлыг хөдөөгийн суманд 14600, аймгийн төвд 13900 төгрөг байхаар тогтоосон боловч зардлуудад хэрхэн хуваарилах аргачлал баталж өгөөгүйгээс тараах материал, сургалтын хэрэглэгдэхүүнд харилцан адилгүй төсөв баталж байна. Иймээс хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалын төсвийг өмнөх жилийн гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байна.


А.3.1.10 Аймгийн хэмжээнд 2017 онд 19008 хүүхдэд 111.6, 2018 онд 19158 хүүхдэд 129.9 сая төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал хуваарилж 1 хүүхдэд дунджаар хичээлийн жилд 6.0 мянган төгрөг ногдож байгаа нь хүүхэд бүрийн насны онцлогт нь тохирсон тараах материал, сургалтын хэрэглэгдэхүүн авахад хүрэлцэхээргүй байна.

Зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянахгүйгээр сарын батлагдсан хуваарийн дагуу олгож байна.

А.3.2.1 Хүүхэд өдрөөр гүйцэтгэлийг хянаж хувьсах зардал болон хүүхдийн хоолны зардлыг санхүүжүүлээгүй байна.

- Сангийн яамнаас хоолны зардлыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн баталсантай холбоотойгоор төсөвт зохицуулалт хийж бусад зардалд гүйлгэн зарцуулдаг зөрчил байгаагаас аймгийн хэмжээнд хүүхдийн тоог илүү тооцож 2017 онд 130.9, 2018 онд 168.6 сая төгрөгийн хувьсах зардлыг сургуулиудад илүү олгосон,
- Сар бүрийн хүүхдийн тоог авч гүйцэтгэлээр төсвийг олгохдоо хяналт хэрэгжүүлэхгүйгээс түүвэрлэн хянасан 11 дотуур байрны хүүхдийн хоолонд 2017 онд 26.6, 2018 онд 26.4 сая төгрөгийг илүү зарцуулсан,
- Булган сум нь 2018 онд тендер шалгаруулалтаар хүүхдийн хүнсний материалыг худалдан авч байсан боловч аймгийн СТСХ-ээс гаргасан жишиг үнээс өдөр үнээр бараа материалыг худалдан авсан зэрэг зөрчлүүд байсаар байна.

А.3.2.2 Зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж санхүүжүүлдэггүйгээс санхүүгийн тайлангийн аудитаар 2017 онд 733.6 сая төгрөг, 2018 онд 3119.4, 2019 онд 1745.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрчээ. Нийт илэрсэн алдаа зөрчлийн 63.4 хувь буюу 3552.0 сая төгрөгийн алдаа зөрчил нь НББ-ийн тайлагналтай холбоотой, 17 хувь буюу 952.7 сая төгрөгийн алдаа зөрчил нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 16 хувь буюу 598.2 хувь буюу 898.2 сая төгрөг нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой, 0.2 хувь буюу 10.0 сая төгрөг нь худалдан авах ажиллагаатай холбоотой байна. Санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай” санал дүгнэлтийн тоо жил бүр буурахгүй байгаа нь БСУГ болон Төрийн сангаас хувьсах зардал болон тогтмол зардлын санхүүжилтэд тавих хяналтыг хэрэгжүүлэн ажилддаггүйтэй холбоотой байна.



/Дүрслэл -9 Санхүүгийн тайлангийн аудитын алдаа зөрчил, дүгнэлтийн байдал/

Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

А.3.2.3 Аймгийн БСУГ нь багшийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулан 2016 онд 6.0 сая төгрөгөөр 2 төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн 675 багш хамруулсан, 2017 онд 18.5 сая төгрөгөөр

7 төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн 692 хүн хамруулсан, 2018 онд 27.2 сая төгрөгөөр 14 төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн 981 багш нарыг хамруулсан, 2019 онд 7 төсөл хөтөлбөрөөр 4898 багш ажилчдыг хамруулсан сургалт, зөвлөгөөнүүдийг зохион байгуулжээ.

А.3.2.4 Батлагдсан хувьсах зардлыг төсөв хүрдэггүйгээс аймгийн хэмжээнд Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 7.3⁴³ дахь заалтыг мөрдөн ажиллаагүй байгаа нь . багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн зарим заалт хэрэгжихгүй байна.

Хувьсах зардал олголтод СТСХ, болон сумдын санхүүгийн албаны дарга болон төрийн сангийн төлөөлөгч нар хяналт тавин ажиллаагүй байна.

А.3.2.5 Аймаг сумдын төрийн сангийн мэргэжилтнүүдэд өдөр тутмын зардлын гүйлгээний хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч хүүхдийн хувьсах зардал олголтод хяналт хийсэн тайлан, илэрсэн зөрчлийг арилгасан талаарх мэдээ, мэдээлэлгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 37.1.1⁴⁴ дахь заалтыг зөрчиж байна.

А.3.2.5 БСУГ нь сумдад ажиллахдаа батлагдсан төсөвт хяналт тавьж ажилладаг гэх боловч ямар хяналтыг хэрхэн хэрэгжүүлсэн талаар тайлан бичиж, албан тоотоор өгсөн зөвлөмж, хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээгүй байгаа нь Боловсролын тухай хуулийн 28.1.4⁴⁵-дахь заалттай нийцэхгүй байна.

Үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг хүүхдийн тоонд бус батлагдсан төсвийн хуваарийн дагуу олгосноос илүү батлагдсан төсвийг бусад зардалд гүйлгэн зарцуулжээ.

А.3.2.6 Үдийн цай хөтөлбөрт 2017 онд 1327.0, 2018 онд 1376.6, 2019 онд 1504.9 сая төгрөгийн төсөв батлагджээ. Үдийн цай хөтөлбөрийн санхүүжилтийг хүүхэд өдрийг сар бүр Төрийн сан болон БСУГ-аас хяналт тавьж ажиллаагүйгээс сургуулиуд бусад зардалд гүйлгэн зарцуулжээ. Сарын төсвийн хуваарийн дагуу хөтөлбөрийн санхүүжилтийг зарцуулах эрх нээгдсэнээр хүрэлцэхгүй байгаа хувьсах зардлуудад гүйлгэн зарцуулсан байна. 14 сургуулийг түүвэрлэн хянахад үдийн цайны зардлаас бусад зардалд гүйлгэн зарцуулжээ.

- 2017 онд 8.7, 2018 онд 23.4, 2019 онд 21.3 сая төгрөгийг бусад зардалд гүйлгэн зарцуулж үдийн цайны зардалд зарцуулснаар тайлагнасан,
- Үдийн цайны батлагдсан дүнгээс 2017 онд 38.9, 2018 онд 40.3, 2019 онд 42.7 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй бусад зардалд гүйлгэн зарцуулсан,
- Жаргалант сумын 1 дүгээр сургууль нь 2017 онд 2.3, 2018 онд 2.3, 2019 онд 5.4 сая төгрөгийг бусад зардалд гүйлгэн зарцуулсан,.
- Эрдэнэбүрэн, Манхан сумын сургуулийн 2018 оны үдийн цайны бүртгэл хангалтгүй, ангийн багшийн журнал болон эмчийн бүртгэл, бага ангийн сургалтын менежер нарын бүртгэл хоорондоо зөрүүтэй,
- Ховд сумын сургууль нь үдийн цайны бүтээгдэхүүнийг аймгийн төвөөс нийлүүлж 5 хоногоор тооцон авч нөөцөлсөн, ирцийн бүртгэлийг тухайн өдрийн жижүүр багшийн бүртгэлээр тооцдоггүй ирвэл зохих хүүхдээр тооцдог,

⁴³ Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын нийт хувьсах зардлын хоёр хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулна.

⁴⁴ төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих

⁴⁵ боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх

Олон улсын төсөл хөтөлбөрөөр үр дүнтэй ажлууд хэрэгжүүлснээр хүүхдийн сурах орчин сайжирсан байна.

А.3.2.7 Аймгийн 14 сургуулийг түүвэрлэн хянахад гадаадын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 9 сургуульд 20 төсөл хөтөлбөр хэрэгжжээ. Дээрх төсөл арга хэмжээнүүдэд нийтдээ 407.8 сая төгрөгийн хөрөнгө 10.2 сая төгрөгийг шагнал урамшуулал, тэмцээн уралдааны урсгал зардалд зарцуулсан байна. Төсөл хөтөлбөрийн хөрөнгийн зарцуулалт нь сургуулийн дансаар дамжаагүй гүйцэтгэгч байгууллагатай төслийг санхүүжүүлэгч байгууллага нь гэрээ байгуулж хөрөнгө оруулалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн байгаа нь ололттой байна. Гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд нь чанартай, үр өгөөжтэй хийгдэж холбогдох сургуулиуд нь хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэж авсан байна. Сайн хэрэгжсэн томоохон төсөл хөтөлбөрүүдийг дурдвал:

- Солонгос улсын соёлын солилцоо төсөл хөтөлбөрийн хүрээнд Жаргалант сумын 7, Прогресс сургуулиудад хийгдсэн “Баярлалаа бяцхан номын сан” төсөл хөтөлбөрийн хүрээнд 143.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдэж тус сургуулиудын сурагчид номын сандаа үйлчлүүлэх тоо эрс нэмэгдсэн,
- Япон улсын ЗГ-ын “Өвсний үндэс” буцалтгүй тусламжийн хүрээнд Буянт сумын сургуулийн цонх солих ажлыг 75.2 сая төгрөгийн өртгөөр хийж гүйцэтгэснээр тус сургуулийн сурагчид дулаан орчинд сурч боловсрох боломж бүрдсэн,
- Солонгос улсын соёлын солилцоо төсөл хөтөлбөрийн хүрээнд Жаргалант сумын 2 дугаар сургуулийн гадна биеийн тамирын талбайд хөл бөмбөгийн талбай хийх ажлыг 61.3, ОНХС-гийн хөрөнгөөр оролцооны 20.0 сая нийт 81.3 сая төгрөгөөр хийснээр хүүхдүүд аюулгүй орчинд сурч боловсрох боломж бүрджээ.

Боловсролын тухай хуульд заасан сургууль хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа хэрэгжихгүй байна.

А.3.2.8 Боловсролын тухай хуулийн 39.11⁴⁶-д заасны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 56/54 тоот тушаалын дагуу аймгийн хэмжээний сургуулиудад сургууль хөгжүүлэх сангүй байна.

Булган сумын 2 дугаар сургууль нь 2018 онд түүхт 45 жилийн ойн баяр арга хэмжээг зохион байгуулж хандив цуглуулжээ. Хандивыг цуглуулахдаа дээрх хамтарсан тушаалын 1.5⁴⁷, 2.1⁴⁸ дахь заалтыг зөрчжээ. Хандиваар байгууллагын нэмэлт дансаар 36.3, бэлэн мөнгөөр 30.5, бараа материалаар 17.8, бай шагналаар 29.0 ОНХС-гаас 12.0 сая нийт 125.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, бараа материал бүрдүүлжээ. Тус хамтарсан журмын 3.2⁴⁹ дахь заалтыг зөрчин төсөл арга хэмжээг санхүүжүүлэх төсөв гаргаагүй, сургуулийн удирдах зөвлөлийн шийдвэр гараагүй байна. Мөн журмын 4.1⁵⁰, 4.5⁵¹-д заасан заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаагүй, хандивын хөрөнгийн зарцуулалтыг хамт олон, ард иргэдэд нээлттэй тайлагнаагүй байна.

⁴⁶ Сургалтын байгууллага нь сургууль хөгжүүлэх сантай байж болох бөгөөд сангийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална

⁴⁷ Санд хөрөнгө хүлээн авах, зарцуулах, тайлагнах дүрмийг сургууль, цэцэрлэгийн зөвлөл, удирдах зөвлөл энэхүү үлгэрчилсэн дүрэмд нийцүүлэн тогтооно.

⁴⁸ Сангийн хөрөнгийг хүлээн авах комиссыг сургалтын байгууллагын захирал, эрхлэгч томилох бөгөөд уг комисс нь сургуулийн нягтлан бодогч, сургалтын алба, эцэг эх, багш, суралцагчдын төлөөллөөс бүрдэнэ.

⁴⁹ Сангийн хөрөнгийг зарцуулах хөтөлбөр, төсөл, арга хэмжээ болон түүний төсвийг дээр дурдсан ерөнхий чиглэлийн хүрээнд багтаан сургууль, цэцэрлэгийн зөвлөл, удирдах зөвлөл батлан гаргана

⁵⁰ Сургалтын байгууллага нь хандив, буцалтгүй тусламжийн зарцуулалт, ашиглалтын талаар мэдээлэл нь нээлттэй, олон нийтийн хяналт тавих нөхцөл бололцоог бүрдүүлсэн байна.

⁵¹ Сангийн хөрөнгийн зарцуулалтын дэлгэрэнгүй тайланг хичээлийн жилийн болон санхүүгийн жилийн төгсгөлд гаргаж хандивлагчдад албан ёсоор хүргүүлнэ.

БҮЛЭГ 2. Бүх нийтийн ерөнхий боловсролыг хөтөлбөр төлөвлөгөөний дагуу эзэмшүүлэн, сургалтын чанарын үнэлгээг хийн дүгнэлт, зөвлөмж өгч байгаа ч сургалтын чанарт дорвитой ахиц гараагүй байна.


Бүх нийтийн боловсролын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу эзэмшүүлж байна.

Б.1.1.1. Боловсролын салбарт бодлогын болон бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт гарч 2006 онд 10 жилийн тогтолцооноос 11 жилийн, 2008 онд 12 жилийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор сургалтын хөтөлбөр олон дахин өөрчлөгдсөн байна.

Б.1.1.2. Монгол улсад Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах, орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсролын салбарын 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийг аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгуулан ажиллажээ.

Б.1.1.3. Боловсролын тухай хуулийн 7.2⁵²-д зааснаар аймгийн хэмжээнд нийт 25 сургуулийн 707 бүлэгт 55187 сурагч хамрагдаж, бага, суурь боловсролд хамрагдах 6-14 насны хүүхдүүдийн хамран сургалт 96,5 хувь болж өмнөх оны мөн үеийнхээс 1,4 хувиар нэмэгдсэн байна.

Дүрслэл 10: Бага, дунд боловсролын хамран сургалт/сүүлийн 3



Б.1.1.4. 2019 онд насан туршийн боловсролын 2 төв, 15 нэгжийн дүйцсэн хөтөлбөрийн сургалтад 833 хүүхэд залуучууд хамрагдсаны 148 нь бага, 366 нь суурь, 319 нь бүрэн дунд боловсролын танхимын болон зайны сургалтад хамрагдсан байна. Дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчдаас 2 хүүхэд ЕБС-д шилжин суралцжээ.

Б.1.1.5. Аймаг, орон нутгийн түвшинд боловсролын хөтөлбөр батлан хэрэгжүүлж байгаа нь сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Тухайлбал, “Чадварлаг багш”, лаборатори сургуулийн үйл ажиллагааг бэхжүүлж, сургалтын цөм хөтөлбөрийг орон нутгийн онцлогтой уялдуулан нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх, Ахмад залуу багш нарын холбоо хамтын ажиллагааг өргөжүүлж туршлага судлах, Багшийн хөгжил-Хичээлийн судалгаа аян өрнүүлэх, “Олон нийтийн оролцоот сургууль” зэрэг хөтөлбөрүүд, мөн багш нарт заах арга, аргачлалыг тодорхой болгосон хөтөлбөр батлан хэрэгжүүлж буй сайн туршлага байна.

Б.1.1.6. Сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт, зорилго, зорилт нь боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр болон суралцагчдын хэрэгцээ, сонирхолд нийцсэн байдлын үнэлгээг 2 хичээлийн жилээр графикаар харуулж, харьцуулалт хийсэн байдлаас харахад :

⁵² бага боловсролыг 5, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 12 жилд тус тус эзэмшүүлнэ

Дүрслэл 11: Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ / авах оноо 4 / авсан байдал Эх сурвалж: БСУГ-ын хяналтын тайлан



- Жаргалант сумын I сургууль авах ёстой 4 онооноос 2 жил дараалан 4 оноо авсан нь ердийн сургалттай ЕБС-аас лаборатори сургуулийн хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын үйл ажиллагааны чанар үзүүлэлт сайн,
- 2017 -2018 оны хичээлийн жилд хөтөлбөрийн хэрэгжилтээс Алтай сумын ЕБС -1.7, Булган, Минжит Булган цогцолбор сургуулиуд 1, Дөргөн, Ховд, Үенч сумын ЕБС -0.9, Зэрэг, Манхан, Мөнххайрхан, Мөст, Мянгад, Цэцэг, Чандмань, Жаргалант сумын 6 сургуулиуд 0.1- 0.5 хувиар өссөн,
- Жаргалант II, Прогресс, Жаргалант VII, Дарви, Буянт сумын ЕБС-иуд 0.5 -0,1 хувиар буурсан,
- Эрдэнэбүрэн сумын ЕБС –ийн эхний хичээлийн жилийн хөтөлбөрийн үзүүлэлт 2.5% буюу хамгийн доогуур, дараагийн хичээлийн жилд ахиц гараагүй байна.

Б.1.1.7. Хөтөлбөрүүдэд хийсэн шинжилгээний үр дүнгээс харахад олон улсын чиг хандлага, үндэсний үнэт зүйл, суралцагчийн сурах нөхцөл байдалд тулгуурласан давуу талтай ч, хөтөлбөрүүд богино хугацаанд өөрчлөгдөж байгаа нь сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоо алдагдах, хөтөлбөрийн үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэн нь дээрх онуудын тоон үзүүлэлт харуулж байна.

Бага, дунд боловсролын сургалтад салбарын яамны баталсан сурах бичгээс гадна нэмэлтээр ном сурах бичиг ашиглаж байна.

Б.1.1.8 Аймгийн хэмжээнд салбарын яамны баталсан сурах бичгийг ашиглаж байгаагаас гадна багш, сурагчдын эрэлт, хэрэгцээнээс хамаарч дараах номуудыг түгээмэл ашиглаж байна.

- Бага боловсролын сургалтын үйл ажиллагаанд О.Азжая “Монгол хэл”, “Математик”, Н. Хажидсүрэн “Өгсүүр өөд”, Б.Туяа “Дасгал ажил Монгол хэл, Математик”, Хүн ба орчин, суралцагч хичээлийн сонгонд явдаг бол М.Чимээчимээ, Г.Тунгалаг, Ш.Отгонбаяр, Д.Мөнхундрага нарын “Сонгон суралцах математик”,
- Дунд ангид С.Чимээсанаа “Орос хэлний хичээлийн гарын авлага”, Ү.Ариунболд “Монгол бичиг уншлагын сурах бичиг”,

Б.1.1.9 Бага ангийн сурагчид 100% дунд, ахлах ангийн сурагчдын 40% нь үнэ төлбөргүй сурах бичиг ашиглаж, дунд, ахлах ангийн 60% -д нь сурах бичиг төлбөртэй ашиглуулах

үйлчилгээнд хамрагджээ. Сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээг нэвтрүүлснээр суралцагчид 100 хувь сурах бичгээр хангагдаж байна.

Эзэмшвэл зохих боловсрол, ур чадварыг олгож байгаа боловч сургалтын чанар харилцан адилгүй байгааг сайжруулах шаардлагатай байна

Боловсрол соёл, урлагийн газраас Ерөнхий боловсролын сургалтын чанарт үнэлгээ хийгдсэн ч бүрэн хамруулж чадахгүй байна.

Б.1.2.2. Боловсрол, соёл, урлагийн газрын даргын 2017 оны А/48 тоот тушаалын дагуу суралцагчдын мэдлэг, чадвар, төлөвшлийг үнэлэх, сургуулийн болон багшийн өөрийн үнэлгээ, сурлагын амжилтын хяналт-шинжилгээний аргыг хавсралтаар баталжээ.

Б.1.2.3 Сургалтын чанарыг сайжруулах зорилгоор БСШУСЯ-ны харьяа БҮТ-өөс зохион байгуулдаг чанарын үнэлгээний судалгааны дүн, сургуулиудын өөрийн үнэлгээний дүн хэт зөрүүтэй байгаад дүгнэлт хийн, чанарыг сайжруулах зорилгоор хичээлийн судалгааг судлагдахуун бүрээр жил бүр шалгалт зохион байгуулж, дүгнэлт гарган зөвлөмж хүргүүлэн ажиллажээ.

Хүснэгт -3 Суралцагчийн мэдлэг, чадварын түвшнийг тогтоосон шалгалтын судалгаа / сүүлийн 3 хичээлийн жилээр/

Д/д Сургуулийн нэр	2016-2017		2017-2018		2018-2019		2016-2017		2017-2018		2018-2019	
	Бага боловсрол						суурь боловсрол					
	тоо	амжилт	тоо	амжилт	тоо	амжилт	тоо	амжилт	тоо	амжилт	тоо	амжилт
1 Алтай	116	71.6	116	60	190	55	348	57.8	342	45.9		
2 Булган I	161	56.5			294	35.6	226	56.2	346	44.8		
3 Булган II	179	42.5	192	73.4	294	40	227	52.9	475	44.6		
4 Буянт	39	71.7			129	41	214	33			298	50.3
5 Дарви	115	53.9			113	52	278	48.6			191	45.5
6 Дуут					61	62	95	77.6	89	77.6	157	44.3
7 Дөргөн					151	40	172	52	210	43		
8 Зэрэг	107	75.7			156	57	305	22.3			255	45.4
9 Манхан	55	90					294	75.5	270	60	253	42
10 Мөст	84	48.8			141	54.3	25	50			25	39.3
11 Мөнххайрхан	72	18.1			121	58.2	257	61.1			302	51.4
12 Мянгад					131	40.5	127	38.8	346	44.8	326	54
13 Ховд	66	48.8			171	45	161	51	168	45		
14 Үөнч	239	48.5	239	48.5	206	40.3	404	45.5	404	45.5		
15 Цэцэг	80	59			23	89	288	49			277	51.2
16 Чандмань	73	65.7					180	46.6			66	57.6
17 Эрдэнэбүрэн					131	40.5			105	45	92	64
18 Жаргалант I	276	86.2	106	72.6			401	48.1				
19 Жаргалант II												
20 Жаргалант III												
21 ЦАЦСургууль			279	89						69		
22 Прогресс	355	49.7					178	56.4	499			
23 Жаргалант YI			307	73					466	50		
24 Жаргалант YII												
25 Хо Их сургууль												
НИЙТ ДҮН	2017	886.7	1239	416.5	2312	750.4	4180	922.4	3720	615.2	2242	545
Эзлэх хувь		59.1		69.4		50.0		51.2		51.3		49.5

Боловсрол соёл урлагийн газраас хийгдэж байгаа сурагчдын сурлагын хяналт үнэлгээг бага болон суурь боловсролд хамрагдах анги бүлгийн хүрээнд хийж, бүрэн дунд боловсролд хамрагдах анги бүлгүүдэд хийгээгүй,


- Аймгийн хэмжээний 25 сургуулиас Жаргалантын II,III,VII, ХИС-ийн дэргэдэх лицей сургууль, насан туршийн боловсрол, Политехник коллеж зэрэг сургуулиудын суралцагчийн мэдлэг, чадварын түвшнийг тогтоосон шалгалт хийгдээгүй,
- Сургуулиудын амжилт жилээс жилд буурч байгаа нь хяналт үнэлгээ нь жил бүр өөр өөр ангиас, өөр өөр хугацаанд авсан хяналт үнэлгээний даалгавар боловсруулалт

хөтөлбөртэй уялдаагүй, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй зэргээс хамаарсан,

- 2017-2019 оны хичээлийн жилүүдэд аймгийн хэмжээнд бага боловсролын 5568 сурагчаас, суурь боловсролын 10142 сурагчаас 15 судлагдахуунаар, хөндлөнгийн хянагчтай /сумын ИТХ, ЗДТГ, сургуулийн зөвлөл, эцэг эхийн зөвлөлийн төлөөлөл/ чанарын судалгаа авахад бага боловсрол 59.5 %, суурь боловсрол 50.6% хувийн дундаж гүйцэтгэлтэй, 2019-2020 оны хичээлийн жилд 5 ангийн 12299 сурагчаас 9 судлагдахуунаар 356 хөндлөнгийн хянагчийг байлцуулан чанарын судалгаа авахад 49 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн,
- 2016-2019 онуудад бага боловсролын хөтөлбөрт хамрагдсан 26858 суралцагчаас 20.7%, суурь боловсролын хөтөлбөрт хамрагдсан 17879 суралцагчаас 56.7% суралцагчийн мэдлэг, чадварын түвшнийг тогтоосон шалгалтад хамрагдсан нь нийт суралцагчдын тоонд харьцуулбал хамрагдалтын хувь маш бага байгаа нь чанарын үнэлгээний хяналт үр нөлөө багатай байна.

Б.1.2.4. Сургалтын үйл ажиллагааны чанар, үр дүн багшийн онолын мэдлэг, ур чадвар, заах арга барилаас ихээхэн шалтгаалж байгаа тул 2016-2017 онд 665 багш, 2017-2018 онд 440 багш, 2018-2019 онд 723 багшаас онолын шалгалт авч, үр дүнг тооцон ажилласан байна.

Дүрслэл -12 ЕБС-ийн багш нарын шалгалтад хамрагдсан дүн мэдээ



Эх сурвалж: БСУГ-ын ажлын тайлан

- 2016-2017, 2017-2018 оны хичээлийн жилд нийт 1105 багш онолын шалгалтад хамрагдаж Цаст-алтай цогцолбор сургууль, Прогресс, Цэцэг, Манхан, Жаргалант VI, жаргалант I, Алтай, Булган I, II, Дарви, Чандмань, Мөнххайрхан сумдын ЕБС-ийн багш нар 90-100% амжилттай,
- Буянт, Дөргөн, Зэрэг, Мөст зэрэг сумдын ЕБС –ийн багш нар 71-86 % амжилттай,
- Дуут, Мянгад, Ховд, Үенч Эрдэнэбүрэн сумдын ЕБС-ийн багш нар хоёр жил дараалан 50-60 % амжилт үзүүлсэн байна.
- Мөн 2018-2019 оны хичээлийн жилд сумдын багш нарын онолын шалгалтын үр дүнд ахиц гарч Булган II, Буянт, Дарви, Дуут, Мөст, Мөнххайрхан, Цэцэг, Чандмань, Эрдэнэбүрэн сумдын ЕБС-ийн багш нар 100% амжилт,
- Булган I сургууль 5, Дөргөн 1, Зэрэг 1, Мянгад 4, Ховд 4, Үенч 3, Жаргалант I сургууль 10, Жаргалант II сургууль 12, Жаргалт III сургууль 6, Цаст Алтай цогцолбор 10, Прогресс сургууль 5, Жаргалант VI сургууль 8, Жаргалант VII сургууль 5 багш нийт 74 багш 60% доогуур үнэлэгдсэн байна.

Б.1.2.5. Мөн тухайн хичээлийн жилүүдэд БСУГ-ийн мэргэжилтнүүд сургуулиудад ажиллахдаа хичээлд сууж зөвлөгөө өгсөн цаг 941, сайжруулж заалгасан хичээл 41, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд суусан 143, сайжруулсан СДҮА 30 багш, ажилчид, суралцагч, эцэг эхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө уулзалт, сурталчилгаа 4523 хүн хамрагдсан байна.

Сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг бодитой үнэлдэггүй байна.

Б.1.2.6 ЕБС-иуд нь сургалтын орчинд нөлөөлөх гадаад болон дотоод орчны эрсдэлийн үнэлгээг гаргаж, тулгамдаж байгаа асуудлуудыг аймаг сумын удирдлагууд болон БСУГ-т уламжлан ажиллажээ.

Б.1.2.7 Боловсрол соёл урлагийн газар болон ЕБС-дад сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсэд хийсэн нэгдсэн судалгаа, дүгнэлт гаргаагүй байна. Тухайлбал: ЕБС-дын байршил, өмчийн хэлбэр, багшийн ур чадвар, сургалтын орчин, анги танхимын хүртээмж, хөтөлбөрийн олон удаагийн өөрчлөлтүүд, эцэг эхийн үүрэг оролцоо, орон нутгийн БСУГ-ын нөлөөлөл гм

Б.1.2.8 Сургалтын сайжруулсан болон цөм хөтөлбөрийн дагуу бага дунд боловсрол олгох үйл ажиллагаанд багш нарт сургалтын хэрэглэгдэхүүн дутмаг байгаа нь сургалтын чанарт нөлөөлөхөөр байна. Сургалтын хэрэглэгдэхүүн хангалтгүйгээс гадна ихэнх багш нар бичгийн цаас, хор, цавуу, ватум цаасыг хувиасаа мөнгө төлж авдаг, шаардлагатай үед эцэг эхээс дэмжлэг авч байна.

Б.1.2.9 Аймгийн БСУГ-ын мэргэжилтнүүд тухайн хичээлийн жилд 1-2 удаа сумын сургуулиудаар зөвлөн туслах, хяналт үнэлгээ хийхдээ зөвхөн хичээлд ажиглалт хийж, зөвлөгөө өгөхөөр хязгаарлагдаж байна. Энэ нь тухайн сургуульд ямар зөрчил илэрч түүнийг хэрхэн арилгаж ажиллах талаар албажуулсан тайлан, баримт бичиггүй байна.

Б.1.2.10 Багш ажилчдаас сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн хувьд багш болон залуу багш нарт зориулсан тэднийг хөгжүүлэх чиглэлээр нэн тэргүүнд чанартай сургалтад хамрагдах хэрэгцээ шаардлага байна.

Боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналтыг хэрэгжүүлжүүлэн, үр дүнг тооцож байгаа ч ахиц гараагүй байна.

Үе шатны хяналтыг хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллаж байгаа боловч чанарт ахиц гараагүй байна.

Б.2.1.1.1.Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тусгасны дагуу 2018 онд олон улсын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд, 2021 онд сурлагын амжилтын олон улсын чанарын судалгаанд хамрагдана хэмээн тусгасны дагуу суралцагчдын сэтгэн бодох чадвар, мэдлэгээ ашиглан асуудлыг шийдвэрлэх, таамаглал дэвшүүлэх, түүнийг шийдвэрлэх аргачлал боловсруулах, үр дүнг өөрийн үгээр тайлбарлах, илэрхийлэх, дүгнэлт гаргах зэрэг чадваруудыг эзэмшихэд дэмжлэг үзүүлэхэд чиглэлээр боловсролын үнэлгээний төвөөс жил бүр судалгаа хийж байна.

Б.2.1.10. БСУГ-аас Жаргалант сумын лаборатори I сургуульд 2, Жаргалантын VI сургуульд 2, ЖаргалантынIII сургууль, Прогресс сургууль, сумдаас Манхан, Буянт, Ховд сумын ЕБС-иуд түүвэрт сонгогдон боловсролын чанарын үнэлгээ хийгдсэн байна.

Б.2.1.10 Боловсролын үнэлгээний төвөөс ЕБС-ийн суралцагчдаас 2018-2019 оны хичээлийн жилүүдэд хийсэн сурлагын чанарын ахицын үнэлгээг сургууль тус бүрээр улсын дундажтай

харьцуулбал хичээл тус бүр харилцан адилгүй байгаа бол аймгийн дунджийг улсын дундажтай харьцуулахад доогуур үзүүлэлтэй шалгагдсан байна.

Орон нутгийн боловсролын газар нь сургалтын хөтөлбөрт хийх хяналт үнэлгээний чанарыг сайжруулах шаардлагатай байна.

Б.2.1. Хяналт шинжилгээг салбарын хууль эрх зүй, хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын хөтөлбөр арга зүй, боловсролын үйлчилгээний хүртээмж, багш нарын бүтээлч үйл ажиллагаа, багшийн бичиг баримтын хөтлөлт, хүүхдийн эрх, оролцоо, багшийн ёс зүй, сонгон судлах хичээлийн үзүүлэлт, сургуулийн гадаад дотоод орчны тохижилт, хүүхэд хамгааллын талаар зохион байгуулсан ажил, төсвийн ил тод байдал зэрэгт ЕБС-ийн ажлыг жил бүр хянаж, үнэлэлт дүгнэлт өгч ажилласан байна.

Хүснэгт -4 Сургуулиудад хийсэн хяналт үнэлгээний дүн

Хичээлийн жил	Алтай	Булган 1	МБЦ	Буянт	Дарви	Дуут	Дөргөн	Зэрэг	Манхан	Мөнххайрхан	Мөст	Мягад	Цэцэг	Үенч	Ховд	Чандмань	Эрдэнбүрэн	Жаргалант -1	Жаргалант -2	Жаргалант -3	Цаст-алтай	Прогресс	Жаргалант-6	Жаргалант -7	ХоИС АС
2017-2018 он	78	75	71	82	78	76	75	74	78	69	69	69	73	73	68	69	68	81	80	75	85	83	76	82	0
2018-2019 он	84	82	77	85	82	85	83	79	78	78	76	76	78	82	75	77	69	92	81	86	86	94	83	87	0
Ахиц	6	7	6	3	4	9	8	5	0	9	7	7	5	9	7	8	1	11	1	11	1	11	7	6	0

Эх сурвалж: БСУГ –ын тайлан мэдээ

Б.2.1.2 Сургалтын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, сургалтын чанарт ахиц гаргахын тулд “Олон нийтийн оролцоот сургууль-хүний хөгжлийн төв” дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлснээр эцэг эхчүүдийг сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулж, сургалтын хөтөлбөрийг сурталчлан зөвлөгөө өгч, хүүхдүүдэд гэрээр нь боловсрол олгох ажлыг өргөжүүлэн, ахмад багш нар, эцэг эхчүүдтэй хамтран ажилласнаар 2019 оны элсэлтийн ерөнхий шалгалтад оролцогчдын гүйцэтгэлийн хувь 50.4-115.6 оноогоор нэмэгдсэн байна.

Б.2.1.3 60-аас доош үнэлгээтэй үнэлэгдсэн багш нарын онолын мэдлэгийг сайжруулах нэмэлт даалгавар зөвлөмж өгч, 2 жил дараалан 60-аас доош үнэлгээтэй үнэлэгдсэн 3 багшид шаардлага хүргүүлж, 2 багшийг түр /3-аас 6 сар/ чөлөөлүүлэн мэдлэг чадвараа нэмэгдүүлэх үүрэг өгч хэрэгжилтийг тооцон ажиллах чиглэлийг сургуулиудын удирдлагад өгч ажилласан байна.

Аймгийн мэргэжлийн хяналтын газраас хийгдсэн төлөвлөгөөт шалгалтаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох боломжгүй байна.

Б.2.2.1 Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас ерөнхий боловсролын сургуулиудад төлөвлөгөөт шалгалт болон зөвлөн туслах үйлчилгээг боловсрол, эрүүл ахуй, барилга, дулаан болон бусад чиглэлээр шалгалтууд хийгдэж илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага, зөвлөмжүүдийг сургуулийн удирдах албан тушаалтанд хүргүүлэн ажиллажээ. Гэвч тухайн байгууллагаас хэрэгжүүлсэн хяналт шалгалтын дагуу хийсэн ажлын мэдээ, тайлан сургуулиудад иж бүрэн бус байна.

Б.2.2.2 Боловсрол хариуцсан байцаагч нь тухайн онуудад шалгалт хийсэн сургуулиуд болон илэрсэн зөрчил дутагдлын талаар товч тайланг емейл хаягаар ирүүлсэн, барилгын болон байгаль орчны чиглэлийн байцаагч нь тэтгэвэрт гарсан, эрүүл ахуйн чиглэлийн байцаагч нь тайлан мэдээ өгөхөөс татгалзсан тул шаардлагатай мэдээллээ бүрэн авч чадаагүй болно.

Б.2.2.3 МХГ-аас шалгалтаар 2017 онд 8 сургууль 11 албан шаардлага, 19 байгууллагад 15 дүгнэлт, 4 байгууллагад 4 дүгнэлт, 2018 онд 7 сургуульд 7 албан шаардлага, 9 байгууллагад

12 дүгнэлт, 5 байгууллагад 5 зөвлөмж, 2019 онд 9 байгууллагад 9 албан шаардлага, 11 байгууллагад 14 дүгнэлт, 2 байгууллагад 2 зөвлөмж өгчээ.

Б.2.2.4 Боловсрол хариуцсан улсын байцаагчийн ирүүлэн хяналт шалгалтаар ЕБС-иудад сургуулийн зөвлөл болон удирдах зөвлөл нь үйл ажиллагааны болон дотоод хяналт шалгалтын дүн, авсан арга хэмжээний талаарх тайланг хамт олон тайлагнадаггүй, тайланг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгөөгүй, физик, технолги, хими, хөгжмийн хичээлийг шаардлага хангасан кабинет лабораторид явуулдаггүй, технологийн хичээлийн дадлага ажлын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүрэлцээ муутай, шаардлага хангасан биеийн тамирын гадна талбайгүй, номын сангийн үйлчилгээ нь стандартад хангаагүй, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдаагүй, бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартад дүн шинжилгээ хийж үр дүн тооцдоггүй, сурлагцагчийн сурлагын явцын талаар эцэг, эхчүүдэд улирал бүр тогтмол мэдээлэх боломж бүрдүүлээгүй зэрэг нийтлэг зөрчлүүд байгааг МХГ-аас ирүүлсэн тайланд тусгасан байна.

Сургуулийн хөгжлийн төлөвлөлтөд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Б.2.2.5 Ерөнхий боловсролын сургуулиудын үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд эцэг эхийн төлөөлөл оролцсон шалгалтыг улирал тутамд хийгдэж илэрсэн дутагдал, зөвлөмжийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагад хүргүүлэн, үдийн цайны чанар стандарт хануулах талаар анхааран ажилласан ч үр дүнд сайжралт гараагүй байна.

Б.2.2.6 Бага дунд боловсролын тухай хуулийн 20.2.2⁵³-д заасны дагуу ЦАЦС-ургууль нь 12 дугаар анги буюу төгсөх ангийн сурагчид, эцэг эх, сургуулийн захиргаатай гурван талт гэрээ байгуулж, багшийн болон эцэг эхийн эрх үүргийг танилцуулсан, суралцагчийн сурах нөхцөлөөр хангах асуудлыг шийдвэрлэх гэрээг байгуулан ажиллаж эцэг, эх, олон нийтийн оролцоог түшиглэн бага сургуулийн гадна тохижилтын ажлыг хийсэн байна.

Б.2.2.7 Жаргалант сумын 3 дугаар сургууль нь “олон нийтийн оролцоот сургууль” дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэн бага ангийн сурагчдын дунд гараас гарт хөдөлгөөнийг өрнүүлж эцэг эх, асран хамгаалагч нарт хүлээн өгдөг ажлыг зохион байгуулан хэвшсэн байна. Мөн сурагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сургуулийн хэмжээнд эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй ариун цэврийн өрөөнүүд “нэг ариун цэврийн цаас-нэг шингэн саван” хөдөлгөөн өрнүүлж давхар бүрийн 00-д байршуулан ажилласан.

Б.2.2.8 Ахлах ангийн сурагчдын дунд сурлагын чанарт дүгнэлт хийх зорилгоор “өөрийгөө хянах хуудас” буюу хүснэгт гарган эцэг эхчүүдэд танилцуулан үр дүнд дүгнэлт хийж дараагийн улирлын ажлын төлөвлөгөөнд тусган тодорхой ажлуудыг зохин байгуулж хэвшсэн байна.

Аудитаар нийт 435.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 9 саналыг УАГ-т уламжилж, 435.5 сая төгрөгийн 20 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар аймгийн ИТХ, ЗД, БСУГ-ын дарга, ЕБС-ын сургуулиудын захирлуудад өгөгдлөө.

⁵³ сургууль хөгжүүлэх бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулахад багш, сурагч, эцэг, эх, олон нийтийн оролцоо, түншлэлийг ханган ажиллах

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- **Салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа зарим бодлогын баримт бичгийг сайжруулан хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн шинэ жилийн эхлэх хугацаа, сургуульд элсэх насыг өөрчилснөөр сургалтын чанар, хүртээмжид ахиц гаргах боломж байна.**
- **Төсвийн төлөвлөлт бодитой бус, тусгай зориулалтын шилжүүлэг, зардлын зарцуулалтад тавих хяналт сул, төсөв хэмнэх боломжийг алдаж байна.**
- **Бүх нийтийн ерөнхий боловсролыг хөтөлбөр төлөвлөгөөний дагуу эзэмшүүлэн, сургалтын чанарын үнэлгээг хийн дүгнэлт, зөвлөмж өгч байгаа ч сургалтын чанарт дорвитой ахиц гараагүй байна.**

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

ҮАГ-Т УЛАМЖЛАХ САНАЛ:

- Боловсролын тухай хууль болон холбогдох тогтоол журамд нэмэлт өөрчлөлт оруулах замаар дараах асуудлыг шийдвэрлүүлэх
- ЕБС-ийн хичээлийн шинэ жилийг 9 дүгээр сарын эхний долоо хоногийн даваа гаригт эхлэхээр зохицуулах
- 6 настай хүүхдийг ЕБС-д элсүүлж байгаа өнөөгийн тогтолцоог эргэн харж хөдөөгийн ард иргэдийн ахуй амьдралтай нийцүүлэн сургуульд элсэх насыг нэмэгдүүлэн өөрчлөх
- Боловсролын салбарын багш ажилчдын хөдөлмөрийн онцлогийг харгалзан тэдгээрийн тэтгэврийг нөхцөлийн тэтгэвэрт хамруулах талаар холбогдох хуульд өөрчлөлт оруулах
- ЗГ-ын 2018 оны 382 тоот тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулж ЕБС-ийн үйлчилгээний бусад ажилчдыг орон нутгийн нэмэгдэлд хамруулах
- ЗГ-ын 2016 оны 242 тоот тогтоолд өөрчлөлт оруулах, бусад хувьсах зардлыг хэрхэн хуваарилах аргачлалыг боловсруулах
- БСШУС-ын 2008 оны 113 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Анги алгасан сургалцах хүсэлтийг шийдвэрлэх журам”-д өөрчлөлт оруулан 1-ээс 5 дугаар ангид анги алгасан суралцах нөхцөлийг бүрдүүлэх
- Сумдын сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд тохирох ном, сурах бичиг, гарын авлага, брайль үсэг, дохионы хэл болон харилцааны бусад арга хэлбэрт хэрэглэх материал, тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээ авах
- Сайдын багцаас шийдвэрлэгдэн хөрөнгө оруулалтаар хийгдэж төсөл арга хэмжээнүүдийг орон нутгийн анхан шатны байгууллагын саналыг үндэслэн бодитой төсөвлөж хуваарилж байх

АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ ТАНАА:

- Боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан баталж түүнд тавих бүх шатны хяналтыг хэрэгжүүлэн ажиллах

- Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн газрын асуудлыг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх
- Зэрэг сумын сургуулийн эзэмшлийн газарт баригдсан хуучин гал тогоог дуудлага худалдаагаар борлуулснаас газарт бусдад шилжих эрсдэл үүссэн байгаа анхаарах

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Б.ДҮГЭРЖАВ ТАНАА:

- Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа засварын ажлын чанар үр дүнг сайжруулах
- Ажлын байрны тодорхойлолт хангахгүй байгаа сургуулийн захирлуудыг журамд нийцүүлэн сонгон шалгаруулалтыг дахин зохион байгуулах
- Аймгийн хэмжээнд ашиглагдахгүй байгаа боловсролын салбарын хуучин барилгуудад их засвар хийж ашиглалтыг сайжруулан ажиллах,

БСУГ-ЫН ДАРГА М.ПҮРЭВХҮҮ-Д

- Хувьсах зардалд тавих дотоод хяналтыг сайжруулан ажиллаж батлагдсан сарын хуваарийн дагуу санхүүжилт олгодог байдлыг зогсоож хүүхдийн тоонд үндэслэн зардлыг санхүүжүүлж байх
- Сургалтын хөтөлбөрийн чанарыг сайжруулахад хийгдэж буй хөндлөнгийн хяналтын хамрагдалтын хүрээг өргөжүүлж, үр дүнг тооцон ажиллах.
- Ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа хийж, дүгнэлт гарган ажиллах.
- Сургалтын үйл ажиллагааны чанар, үр дүн багшийн онолын мэдлэг, ур чадвар, хичээл заах арга барилаас ихээхэн шалтгаалж байгаад дүгнэлт хийж багшийн онолын мэдлэгийг дээшлүүлэх талаар үе шаттай ажлыг зохион байгуулах .
- Аймгийн хэмжээнд англи хэлний лингафоны кабинетаар 88 хувь нь хангагдаагүй байгаад дүгнэлт хийж, энэ асуудлыг орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрүүдийн эх үүсвэрээр шийдвэрлүүлэх
- Хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөрөөс хуваарилагдсан хөрөнгийн талаарх судалгааг нарийн гаргах
- Цахим статистик мэдээллийг системд оруулах арга хэмжээг сайжруулах мэдээллийн үнэн бодитой байдлыг ханган, хяналтыг хэрэгжүүлэх
- Ховд, Эрдэнэбүрэн сумын сургуулийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллах
- Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэн ажиллах ажлын төлөвлөгөө гарган, биелэлтийг тооцон 2021 оны 3 сарын 25-ны дотор ирүүлэх

АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ЗАХИРАЛ НАРТ:

- Сургалтын стандартад эрсдэлийн үнэлгээ хийж, багш нарын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэн сурлагын чанарт ахиц гаргах талаар үе шаттай ажлыг зохион байгуулж ажиллах
- Сургалтын ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, биелэлтийг тооцон MNS 6782:2019 стандартыг мөрдөж ажиллах

- Боловсролын сайдын тушаалаар баталсан орон тооны норм нормативыг мөрдөн, ажлын байрны тодорхойлолт шалгуурт заасан албан тушаалтнуудыг томилж байх.
- ЕБС-ыг хяналтын камертай болох түүнийг ашиглах, бичлэг хадгалах, хянах, дүрэм журамтай болгох
- Зардал хооронд гүйлгэн зарцуулдаг байдлыг таслан зогсоож хэмнэгдсэн дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цайны зардлыг төсөвт бүрэн төвлөрүүлэн ажиллах
- Сургуулийн захирлын дэргэдэх дотоод хяналтын багийн үйл ажиллагааг удирдлагаар ханган үр дүнг улирал тутам хамт олонд мэдээлж байх,

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:



ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР:

Саналд өгөх тайлбар	
Тайлбар 1.	Саналыг хянаж үзээд А.1.1.4-д ...Жаргалант сумын 7, Буянт сумын сургуулиас бусад 22 захирлыг..., ...сургуулийн зөвлөл... гэж найруулгын өөрчлөлт оруулсан.
Тайлбар 2.	Саналыг хянаж үзээд А.2.2.2-д ...сумын биеийн тамирын заалны дээвэрт... гэж найруулгын өөрчлөлт оруулсан
Тайлбар 3.	Саналыг хянаж үзээд А.2.2.17-д ...2017 онд 88.5, 2018 онд БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтын программ цахим халдлагад өртөж мэдээллийн бааз устсан, 2019 онд 265.1 сая...гэж найруулгын өөрчлөлт оруулсан.

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 33

Ховд

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1, 1.3 Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 тоот тушаалаар баталсан "гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 12.40 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал үр дүнд хийсэн" гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитын тайлангаар илэрсэн алдаа зөрчил зөвлөмжийг статистик мэдээний маягтын дагуу бүртгэж биелэлтийг тооцон ажиллахыг гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор /Д.Нарантуул/-д үүрэг болгосугай.

3. Гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнг, аймгийн Боловсрол соёл урлагийн газар, Аймгийн засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлж аудитын тайланг сургуулийн удирдах бүрэлдэхүүн, олон нийтэд танилцуулан сайтад байршуулахыг аудитын багт хариуцуулсугай.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилт үр дүнг танилцуулахыг 2021 оны 03 дугаар сарын 01-ны дотор танилцуулахыг аймгийн БСУГ-ын дарга М.Пүрэвхүүд зөвлөсүгэй.

5. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 14 хонгийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /Д.Нарантуул/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер /А.Цэцэгсүрэн/-д тус тус даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

